

ЗӨВШӨӨРСӨН:  
ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ  
ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  
*Ч.Эрдэмбүлэг*



БАТЛАВ:  
САЛБАР  
УХААНЫ НУУЦАЛАН  
ХҮҮХЭД СУДЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  
Т.БОЛОРМАА

ХҮНИЙ ИХ ЭМЧИЙН “ХҮҮХЭД СУДЛАЛ”  
ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН  
ХӨТӨЛБӨР

Индекс: S(r) 0912-17

Хугацаа: 2 жил

УЛААНБААТАР ХОТ

## **БОЛОВРУУЛСАН АЖЛЫН ХЭСЭГ:**

**Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, Эх нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв II-ийн төлөөлөл:**

Т.Болормаа	Эрүүл мэндийн яамны дэргэдэх Хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн дарга, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хүүхдийн эмнэлэг хариуцсан дэд захирал, Анагаах ухааны доктор, Клиникийн профессор, Зөвлөх зэргийн эмч, Монгол улсын Хүний гавьяат эмч
Б.Баясгалантай	Эрүүл мэндийн яамны дэргэдэх Хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, Анагаах ухааны доктор, Дэд профессор, Зөвлөх зэргийн эмч
Г.Эрдэнэтuyaа	Эрүүл мэндийн яамны дэргэдэх Хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Хүүхдийн анагаахын тэнхимиин эрхлэгч, Анагаах ухааны доктор, Дэд профессор, Зөвлөх зэргийн эмч
Д.Агиймаа	Эрүүл мэндийн яамны дэргэдэх Хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Хүүхдийн анагаахын тэнхимиин ахлах багш, Анагаах ухааны доктор, Дэд профессор, Зөвлөх зэргийн эмч
У.Цэвэгмид	Эрүүл мэндийн яамны дэргэдэх Хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төвийн Хүүхдийн эмнэлэг хариуцсан дэд захирал, Анагаах ухааны доктор, клиникийн профессор

## **Хамтран оролцсон:**

Ч.Эрдэнэцэцэг	Эрүүл мэндийн яамны дэргэдэх Хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Мэсзаслын тэнхимиин ахлах багш, Анагаах ухааны доктор, Зөвлөх зэргийн эмч
Ч.Цэнгэлмаа	Эрүүл мэндийн яамны дэргэдэх Хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн хүүхдийн нүдний эмч, Анагаах ухааны доктор, Зөвлөх зэргийн эмч
Д.Наранцэцэг	Эрүүл мэндийн яамны дэргэдэх Хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Нярайн эрчимт эмчилгээний тасгийн эрхлэгч, Анагаах ухааны магистр, Тэргүүлэх зэргийн эмч

**ХЯНАСАН:**

П.Эрхэмбаяр

Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны  
удирдлагын газрын дарга, Нийгмийн эрүүл  
мэндийн магистр

Д.Дондогмаа

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Хүний  
нөөцийн хөгжлийн албаны ахлах  
мэргэжилтэн, Анаагаах ухааны магистр

Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн  
2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн  
17 дугаар тогтоолоор зөвшөөрөв.

ХҮНИЙ ИХ ЭМЧИЙН “ХҮҮХЭД СУДЛАЛ” ҮНДСЭН  
МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР  
НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Монгол улсын Тогтвортой хөгжлийн зорилтыг хангахад хүүхдийн эрүүл мэндийг сахин хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эндэгдлийг тууштай бууруулахад чиглэсэн арга хэмжээний хүрээнд хүүхэд, нярайд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, энэ чиглэлээр ажиллах хүний нөөцийг чадавхижуулах зорилгоор төгсөлтийн дараах сургалтыг тогтмол, тасралтгүй явуулах асуудал нэн чухал байна.

Монгол улсын төрөөс хүн амын эрүүл мэндийг сайжруулах чиглэлээр баримтлах бодлогод “... төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд, мэргэжлийн нийгэмлэг, холбоодыг тухайн мэргэжлээрээ тусламж, үйлчилгээний хөгжлийг тодорхойлогч нь байж, улсын хэмжээний лавлагaa шатлалын түвшиний дүгнэлт гаргах, эмнэлзүйн заавар, стандарт, хөтөч боловсруулах, судалгаа, шинжилгээ хийх, эмнэлгийн мэргэжилтэнг сургах, бусад эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах чадавхитай болгон хөгжүүлэх; эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн өмнөх сургалтыг салбарын бодлого, хүн амын эрүүл мэндийн эрэлт, хэрэгцээтэй уялдсан хүний нөөцийг төлөвлөж шийдвэрлэдэг болох; эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн бусад ажилтны төгсөлтийн дараах сургалтын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн шинэчилж, сургалтын түшиц эмнэлгийн сүлжээг байгуулах, сургалтын үйл ажиллагаанд түшиц эмнэлэг, мэргэжлийн нийгэмлэг, холбоо, суралцагчийн оролцоог нэмэгдүүлэх” гэж тусгасан.

Мөн Монгол Улсын Засгийн газраас баталсан “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” Үндэсний хөтөлбөрт “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндэд ээлтэй орчин бүрдүүлэх, эх, хүүхдийн сэргийлж болох эндэгдлийг бууруулахад бусад салбарын чиг үүргийг тодорхойлж, хамтран ажиллах; Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийг бэхжүүлэх, эмч, эмнэлгийн мэргэжилтнийг ажлын байранд болон эмнэлэг хооронд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, жирэмсэн эхчүүд, эх барих, нярай, хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн яаралтай тусламжийн сургалтад тогтмол хамруулах....” гэж заасан.

Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/184 дүгээр тушаалаар “Хүүхэд судлал”-ын үндсэн мэргэшлийн сургалтын чиглэл, индексийг баталж, сургалтыг 2 жилийн хугацаатай байхаар заасан.

Улсын Их Хурлаас 2016 онд шинээр баталсан “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль”-аар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэшлийн төв төдийгүй нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвд төгсөлтийн дараах сургалт

эрхлэхээр зохицуулсан тул Эрүүл мэндийн яамны дэргэдэх Хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөл дээрх бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор “Хүүхэд судлал”-ын үндсэн мэргэшлийн сургалтын хөтөлбөрийг боловсруулсан.

## ХОЁР. ЭРХЭМ ЗОРИЛГО

Хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд нийцэх, хүүхдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх цогц чадамж бүхий эмч бэлтгэх

## ГУРАВ: АЛСЫН ХАРАА

Хүүхэд судлалын үндсэн мэргэшлийн сургалтын хөтөлбөрөөр бэлтгэх **эмчийн дүр зураг**:

Хүүхэд, нярай, өсвөр үеийн эрүүл мэндийг хамгаалах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үүрэг хариуцлагаа бүрэн ойлгосон, хүүхдийн суурь өвчин, хүүхдэд зонхилон тохиолдох өвчин, эмгэгийн оношилгоо, эмчилгээ хийхэд шаардагдах мэдлэг, ур чадварыг эзэмшсэн, үйлчлүүлэгчид энэрэх сэтгэлээр хандаж, эмчийн ёс зүйг чандлан баримталдаг, багаар ажиллан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үр дүнтэй үзүүлж чаддаг хүүхдийн эмч байна.

## ДӨРӨВ: СУРГАЛТЫН ЗОРИЛТ

Алсын харааг биелүүлэхэд чиглэсэн дараах цөм чадамжтай хүүхдийн эмч байна:

1. Хүүхдийн эмч байх (*Pediatrician*)
2. Мэргэжлийн байх (*Professional*)
3. Суралцагч (*Learner*)
4. Харилцагч (*Communicator*)
5. Хамтрагч (*Collaborator*)
6. Хүн ам, эцэг эх, асран хамгаалагч, өсвөр үеийнхний эрүүл мэндийн зөвлөгч (*Health Advocate for society, parents, guardians and teenagers*)
7. Зохион байгуулагч, манлайлагч (*Leader*)

Энэхүү цогц чадамж бүхий хүүхдийн эмч болохын тулд дараах дэд чадамжийг эзэмшиж, бие даан гүйцэтгэж чаддаг болно. Үүнд:

### 1. Хүүхдийн эмч (*Pediatrician*):

Эзэмших мэдлэг:

- Хүүхдэд зонхилон тохиолдох өвчний шинж тэмдгийг (*signs and symptoms*) таньж, ялган оношлох, анхан шатны арга хэмжээг авах
- Хүүхдийн өвчний оношилгоо (*diagnosis*), эмчилгээний (*treatment*) талаар орчин үеийн судалгаа, нотолгоот мэдээлэлтэй танилцах, UpToDate-ийн эмнэлзүйн заавар, удирдамжийг судлах
- Хүүхдийн суурь эмгэг, хүүхдэд зонхилон тохиолддог эмгэг өөрчлөлт, хүндрэлүүдийг эрт илрүүлж, оношлох, эмчлэх төлөвлөгөөг гаргах

- Өсвөр үеийн нөхөн үржихүйн эрүүл мэнд, хүсээгүй жирэмсэлтээс сэргийлэх, гэр бүл төлөвлөлтийн орчин үеийн аргын талаар зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх
- Хүүхдийн өвчнийг оношлоход шаардлагатай эмнэл зүйн, дүрс оношилгооны, молекул биологийн, эд эсийн шинжилгээ, оношилгоонд дүн шинжилгээ хийх
- Өсвөр үеийн сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал (дэлгэцэд хамааралтай болох.. г.м)-аар тусlamж үйлчилгээ үзүүлэх, зөвлөгөө өгөх
- Хүүхдийн өвчнийг эрт үед нь оношлох орчин үеийн арга технологид суралцах
- Бага насны хүүхдэд зонхилон тохиолдох эмгэгийн ялган оношлох мэдлэгтэй болох

#### **Эзэмших ур чадвар:**

- Хүүхдийн эрүүл мэндийн асуудлаар эцэг, эх, асран хамгаалагчид зөвлөгөө өгөх, тусlamж үзүүлэх ур чадварыг эзэмших
- Хүүхдэд үзүүлэх яаралтай тусlamжийг цаг алдалгүй үзүүлэх ур чадварт суралцах, дадлагажих
- Нярайг төрмөгц төрөх өрөөнд нярайн эрт үеийн нэн шаардлагатай цогц тусlamжийг үзүүлэх, нярайн эрүүл мэндийн талаар эх болон ар гэрийнхэнд зөв ойлгуулах ур чадварт суралцаж, дадлагажих
- Нярайг амьсгалахад туслах ур чадварыг бүрэн эзэмшсэн байх (HBB helping baby breath)
- Нярайн сэхээн амьдруулалт (NRP), сэхээн амьдруулалтын үеийн багаар ажиллах чадварыг эзэмших (Үүнийг хүүхдийн эмчийн түвшинд хийж сураад гарсан байх нь Манай орны хувьд орон нутагт дандаа хүүхдийн эмч жижүүр хийх гэх мэт асуудал тулгарч ажиллана )
- Нярайн эрт илрүүлгийг хийх чадварт суралцах, Нүдний улаан рефлексийг шалгах
- Нярай, хүүхдийн мэдээгүйжүүлгийн онцлог, яаралтай тусlamжийн зохион байгуулалттай танилцаж, амь тэнссэн үеийн тусlamжийг зохион байгуулах, багаар ажиллах чадвартай болох
- Төрөлхийн хөгжлийн гажиг, нярайд стигмуудийг сэжиглэх үнэлгээ хийх
- Хүүхдийн амьсгалын тогтолцооны эмгэгийг ялган оношлох, эмчлэх ур чадварт суралцаж, дадлагажих
- Хүүхдийн зүрх – судасны тогтолцооны эмгэгийг ялган оношлох, эмчлэх ур чадварт суралцаж, дадлагажих
- Хүүхдийн цус, цус төлжүүлэх эрхтэн тогтолцооны эмгэгийг ялган оношлох, эмчлэх ур чадварт суралцаж, дадлагажих
- Хүүхдийн бөөр-шээсний замын тогтолцооны эмгэгийг ялган оношлох, эмчлэх ур чадварт суралцаж, дадлагажих
- Хүүхдийн дотоод шүүрлийн тогтолцооны эмгэгийг ялган оношлох, эмчлэх ур чадварт суралцаж, дадлагажих
- Хүүхдийн цочмог халдварт өвчин, эмгэгүүдийг эмгэгийг ялган оношлох, эмчлэх ур чадварт суралцаж, дадлагажих

- Хүүхдийн амь тэнссэн үеийн сэхээн амьдруулах, эрчимт эмчилгээний үндсэн зарчмыг эзэмшиж, дадлагажих,
- Хүүхдийн мэс заслын эмгэгийн оношилгоо, эмчилгээний үндсэн зарчмыг эзэмших, оношлох, мэс заслын дараах хүндрэлээс сэргийлэх, гарсан хүндрэлийг эрт оношлож, эмчлэх чадварыг эзэмших
- Хүүхдийн харшлын эмгэгийг ялган оношлох, эмчлэх ур чадварт суралцаж, дадлагажих
- Хүүхдийн чих-хамар-хоолойн эмгэгийг ялган оношлох, эмчлэх ур чадварт суралцаж, дадлагажих
- Хүүхдийн нүдний эмгэгийг ялган оношлох, эмчлэх ур чадварт суралцаж, дадлагажих
- Хүүхдийн дархлаа тогтолцооны эмгэгийг ялган оношлох, эмчлэх ур чадварт суралцаж, дадлагажих
- Хүүхдийн удамшлын эмгэгийг ялган оношлох, эмчлэх ур чадварт суралцаж, дадлагажих
- Хүүхдийн хавдрыг эрт илрүүлэх, эмчилгээний арга боловсруулах, эмчлэх чадварыг эзэмших
- Өсвөр үеийнхний нөхөн үржихүйн эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг тодорхойлж, тэдэнд тусламж үзүүлэх чадварыг эзэмших

#### **Эзэмших хандлага:**

- Үйлчлүүлэгч бүрээс асуумж авах, бодит үзлэг хийх, үйлчлүүлэгчийн сэтгэл зүй, нийгмийн нөхцөл байдлыг үнэлж, оношилгоо, эмчилгээ, хяналтын төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх
- Эрүүл мэндийн байгууллагад ашиглагдах анхан шатны бүртгэл, тайлангийн маягтыг батлагдсан журмын дагуу хөтлөх, хугацаанд нь тайлагнах
- Эмнэлзүйн тохиолдлын хэлэлцүүлэг, семинар, эрдэм шинжилгээний хуралд оролцох, багаар ажиллах, асуудлыг шийдвэрлэх дадалд суралцах
- Алсын зайн оношилгоо, зөвлөгөөнд оролцох, суралцах
- Үйлчлүүлэгчийн хувийн нууцыг хадгалах,
- Үйлчлүүлэгч, тэдний гэр бүлд энгийн ойлгомжтой үг, хэллэг ашиглан зөвлөгөө өгөх
- Жендерийн тэгш байдал, хүчирхийлэл, бэлгийн хүчирхийллээс сэргийлэх, зөвлөгөө өгөх

#### **2. Мэргэжлийн байх (*Professionalism*)**

- Орон нутагт өөрийн мэргэшлээр хувь нэмэр оруулах хүсэл эрмэлзэлтэй байх
- Өвчтөн болон түүний ар гэрийг хувь хүний хувьд хүндэтгэж, хамгийн оновчтой зөв шийдвэр гаргахын төлөө ажиллах
- Хувь хүний онцлогийг харгалzan өвчтөн болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, төрөл, садны хүнтэй хүндэтгэлтэй харилцах

#### **3. Суралцагч (*Learner*)**

- Өөрийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлэхийн тулд цөм хөтөлбөрийн сургалтад хамрагдах,
- Бие даан тасралтгүйгээр суралцах, UpToDate зэрэг орчин үеийн мэдээллийн эх үүсвэрийг ашиглах, судлах, дүн шинжилгээ хийх,
- Хамтран суралцагч эмч, бусад эмнэлгийн мэргэжилтэнд заах замаар өөрийн мэдлэг, ур чадвараа сайжруулах,
- Өөрийгөө хөгжүүлэх, стресс менежмент хийх арга барилд суралцах,
- Өвөрмөц хэрэгцээ шаардлагатай үйлчлүүлэгчтэй харьцах арга барилд суралцах.

#### **4. Харилцагч (*Communicator*)**

- Хүүхэд, эцэг, эх асран хамгаалагчидтай зүй зохистой үг хэллэг ашиглан зөв боловсон харилцах,
- Хүүхэд, эцэг, эх асран хамгаалагчид шаардлагатай мэдээллийг тэдэнд ойлгомжтой, хялбар үг хэллэг ашиглан тайлбарлах,
- Шаардлагатай тохиолдолд үйлчлүүлэгчийн оношилгоо, эмчилгээний талаар бусад мэргэжлийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнтэй болон эрүүл мэндийн бусад байгууллагуудтай зөвлөлдөх,
- Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнуудтай зөв боловсон эрэг хандлагаар харилцах арга зүйг суралцах.

#### **5. Хамтрагч (*Collaborator*)**

- Хүүхдийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээтэй холбоотой асуудлаар бусад эмч, мэргэжилтнүүд, хамтран суралцагчидтай мэдээлэл солилцож, хамтран ажиллах,
- Эмнэлгийн бусад тасгийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнтэй мэргэжлийн мэдлэг, мэдээллээ хуваалцаж хамтран ажиллах.

#### **6. Зөвлөгч (*Advisor*)**

- Хүүхдийн өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, тусlamж, үйлчилгээ үзүүлэх, сургалт сурталчилгаа явуулах,
- Нярайн эрт үеийн нэн шаардлагатай багц тусlamжийн чиглэлээр тусlamж үйлчилгээ үзүүлэх, эхчүүд, гэр бүлд сургалт сурталчилгаа явуулах,
- Анхан шатны түвшинд хүүхэд, өсвөр үеийн эрүүл мэндийн тусlamж үзүүлж буй эмч, эмнэлгийн мэргэжилтэнтэй хамтран ажиллаж, шаардлагатай тохиолдолд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх,
- Өсвөр үеийн нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлт, жендерийн тэгш байдал, хүүхдийн хүчирхийллээс сэргийлэх чиглэлээр мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх,
- Хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд тохирсон арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

#### **7. Зохион байгуулагч, манлайлагч (*Leader*)**

- Эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг зохицуулах, манлайлан ажиллах үүргээ ухамсарлах,

- Хүүхдэд эрүүл мэндийн тусlamж үйлчилгээ үзүүлдэг эмнэлэг, эрүүл мэндийн төв дэх тусlamж, үйлчилгээ үзүүлэх багийг манлайлан ажиллах үргээ ухамсарлаж, арга барилд суралцах,
- Хүүхдийн яаралтай тусlamж шаардсан тохиолдолд багийн удирдан зохион байгуулж манлайлж оролцох.

## ТАВ. СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ

### **5.1 Сургалтын чиглэл, хугацаа, байршил**

- “Хүүхэд судлал” чиглэлээр 25 тойролтыг хийж, хүүхдийн эмчийн эзэмшвэл зохих цогц чадамжийг эзэмшсэн байна.
- Сургалтын нийт хугацаа 2 жил байна. Тойролтын хугацааг долоо хоногоор тооцно. Суралцагч эмчийн өдөр тутмын болон 7 хоногийн үйл ажиллагааны тодорхой хуваарийг сургалтын албанаас боловсруулна.
- Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлэг, Эх нярай эмэгтэйчүүдийн үндэсний төв нь сургалтын үндсэн байгууллага байна. Тухайн тойролтын дадлага сургалтад шаардагдах өвчтөний тоо хангалтгүй, орчин бүрдээгүй тохиолдолд Улаанбаатар хотын дүүргүүдийн Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн яаралтай тусlamжийн тасаг, хүүхдийн эрчимт эмчилгээний тасаг, хүүхдийн тасгуудад, мөн Хавдар судлалын үндэсний төв, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Арьсны өвчин судлалын үндэсний төв, Улсын гуравдугаар төв эмнэлэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах үндэсний төв, Эмгэг судлалын үндэсний төв зэрэг сургалт эрхлэгч байгууллага, Хүүхдийн анагаахын мэргэжлийн нийгэмлэг, холбоотой сүлжээ үүсгэн хамtran ажиллана.
- Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хүүхдийн эмнэлэг, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлэг, Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төвийн Хүүхдийн эмнэлгийн амбулатори, хэвтэн эмчлүүлэх төрөлжсөн мэргэжлийн тасгууд, хурлын танхим, сургалтын анги танхимд эмнэлзүйн сургагч багшийн удирдлага дор дадлага хийж, үйлчлүүлэгчтэй харилцах, асуудлыг нь хамtran шийдэх байдлаар сургалт явагдана.

### **5.2 Зайлшгүй суралцах шаардлагатай тойролт, шинж тэмдэг, өвчин, гардан үйлдэл**

Суралцагч эмч сургалтын төгсгөлд хүүхэд, нярайн оношилгоо, эмчилгээний асуудлыг бие даан шийдвэрлэх түвшинд хүрэхийн тулд эмнэлзүйн сургагч багшийн хяналт дор яаралтай тусlamж, амбулаториор ирэх өвчтөн, хэвтэн эмчлүүлэх өвчтнийг хариуцан эмнэлгийн тусlamж үзүүлэх явцдаа дараах тойролт, гардан үйлдлийг гүйцэтгэж, туршлага хуримтлуулна.

#### **5.2.1. Шинж тэмдэг, хамшинж (*signs and symptoms*) (аль ч тойролтод тохиолдох):**

Өвчний түүх, бодит үзлэгт үндэслэн эрэмбэлэн ангилж, ялган оношлогоо хийн, анхан шатны эмчилгээг эхлүүлж чаддаг болох:

1. Халууралт (*Fever*)
2. Шарлалт (*Jaundice*)
3. Толгой өвдөлт (*Headache*)
4. Ухаан алдалт, баларталт (*Altered level of consciousness*)
5. Таталт (*Seizure*)
6. Амьсгаадалт (*Dyspnea*)
7. Ханиалгалт, цэр гаралт (*Coughing, Excretion sputum*)
8. Цээжээр өвдөлт (*Chest pain*)
9. Зүрх зогсолт (*Cardiac arrest*)
10. Цустай бөөлжилт (*Hematemesis*)
11. Цустай өтгөн, цустай гүйлгэлт (*Melena*)
12. Дотор муухайралт, бөөлжилт (*Nausea, Vomiting*)
13. Хэвлийн өвдөлт (*Stomachache*)
14. Суулгалт (*Diarrhea*)
15. Шингэн алдалт (*Dehydration*)
16. Нуруугаар өвдөлт (*Back pain*)
17. Мөчдийн саажилт (*Paralysis*)
18. Сэтгэл гутрал (*Depression*)
19. Хаван (*Edema*)
20. Үений өвдөлт (*Arthralgia*)
21. Лимфийн булчирхайн томролт (*Lymph node swelling*)
22. Цус алдалт (*Hemorrhagic tendency*)
23. Нярай үеийн асуудлууд (*Early essential newborn care*)
24. Өсөлт хөгжлийн эмгэгтэй өөрчлөлттэй хүүхдийг таньж илрүүлэх үнэлгээ (*Evaluation for growth and developmental disorders of children*)
25. Тууралтат өвчин (*Skin rash*)
26. Шок (*Shock*)

#### **5.2.2. Зайлшгүй суралцаж, таньж мэдэх шаардлагатай өвчин (Өвчний олон улсын 10 дугаар ангилаар (ICD-10 code)):**

1. Цусны эргэлтийн ба амьсгалын тогтолцоог хамарсан шинж тэмдэг ба зовиур (*Symptoms and signs involving the circulatory and respiratory systems*) R00-R09
2. Хоол боловсруулах тогтолцоо ба хэвлийн хэндийг хамарсан шинж тэсдэг ба зовиур (*Symptoms and signs involving the digestive system and abdomen*) R10-R19
3. Арьс ба арьсан доорх эслэгийг хамарсан шинж тэмдэг ба зовиур (*Symptoms and signs involving the skin and subcutaneous tissue*) R20-R23
4. Мэдрэл ба яс-булчингийн тогтолцоог хамарсан шинж тэмдэг ба зовиур (*Symptoms and signs involving the nervous and musculoskeletal systems*) R25-R29
5. Шээх тогтолцоог хамарсан шинж тэсдэг ба зовиур (*Symptoms and signs involving the genitourinary system*) R30-R39

7. Дуу хоолой ба хэл яриаг хамарсан шинж тэмдэг ба зовиур (*Symptoms and signs involving cognition, perception, emotional state and behavior*) R40-R46
8. Ерөнхий шинж тэмдэг ба зовиур (*Symptoms and signs involving speech and voice*) R47-R49
9. Ерөнхий шинж тэмдэг ба зовиур (*General symptoms and signs*) R50-R69
10. Цусны шинжилгээний хэвийн бус үзүүлэлт, тодорхой оношгүй (*Abnormal findings on examination of blood, without diagnosis*) R70-R79
11. Шээсний шинжилгээний хэвийн бус үзүүлэлт, тодорхой оношгүй (*Abnormal findings on examination of urine, without diagnosis*) R80-R82
12. Биеийн бусад шингэн, бодис ба эдийн шинжилгээний хэвийн бус үзүүлэлт, тодорхой оношгүй (*Abnormal findings on examination of other body fluids, substances and tissues, without diagnosis*) R83-R89
13. Үйл оношийн болон дүрслэл оношлогооны хэвийн бус үзүүлэлт, тодорхой оношгүй (*Abnormal findings on diagnostic imaging and in function studies, without diagnosis*) R90-R94
14. Нас баралтын тодорхойгүй шалтгаан (*Ill-defined and unknown cause of mortality*) R95-R99
15. Халдварт ба шимэгчit зарим өвчин A00-B99 (*Certain infectious and parasitic diseases*)
16. Өмөн C00-D49 (*Neoplasms*)
17. Цус, цус төлжүүлэх эрхтэний өвчин ба дархлааны механизм хамарсан зарим эмгэг D50-D89 (*Diseases of the blood and blood-forming organs and certain disorders involving the immune mechanism*)
18. Дотоод шүүрэл, тэжээлийн ба бодисын солилцооны өвчинүүд E00-E89 (*Endocrine, nutritional and metabolic diseases*)
19. Сэтгэцийн ба зан төрхийн эмгэг F01-F99 (*Mental, Behavioral and Neurodevelopmental disorders*)
20. Мэдрэлийн тогтолцооны өвчинүүд G00-G99 (*Diseases of the nervous system*)
21. Нүд ба түүний дайврын өвчинүүд H00-H59 (*Diseases of the eye and adnexa*)
22. Чих ба хөхлөг сэргэнгийн өвчинүүд H60-H95 (*Diseases of the ear and mastoid process*)
23. Зүрх-судасны тогтолцооны өвчинүүд I00-I99 (*Diseases of the circulatory system*)
24. Амьсгалын тогтолцооны өвчинүүд J00-J99 (*Diseases of the respiratory system*)
25. Хоол боловсруулах тогтолцооны өвчин K00-K95 (*Diseases of the digestive system*)
26. Арьс ба арьсан доорх эслэгийн өвчин L00-L99 (*Diseases of the skin and subcutaneous tissue*)
27. Шээс бэлгийн тогтолцооны эмгэгүүд N00-N99 (*Diseases of the genitourinary system*)
28. Перинаталь үед үүссэн зарим эмгэг P00-P96 (*Certain conditions originating in the perinatal period*)
29. Төрөлх гажиг, гаж хөгжил ба хромосомын эмгэг Q00-Q99 (*Congenital malformations, deformations and chromosomal abnormalities*)

30. Өөр бүлэгт ангилаагүй шинж тэмдэг, зовиур, эмнэлзүйн ба лабораторийн хэвийн бус үзүүлэлтүүд R00-R99 (*Symptoms, signs and abnormal clinical and laboratory findings, not elsewhere classified*)
31. Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг S00-T88 (*Injury, poisoning and certain other consequences of external causes*)
32. Эрүүл мэндийн байдал болон эрүүл мэндийн байгууллагад хандахад нөлөөлөх хүчин зүйлс Z00-Z99 (*Factors influencing health status and contact with health services*)

### **5.2.3 Хүүхдэд зонхилон тохиолдох өвчин, эмгэг /Childhood common disease/**

1. Хүүхдийн суурь эмгэг (*Basic common disorders*)
2. Сульдаа (*Rickets*)
3. Цус багадалт (*Anemia*)
4. Тураал (*Malnutrition*)
5. Шүүдэст эмзэгшил (*Diathesis exudation*)
6. Уушгины хатгалгаа (*Pneumonia*)
7. Гуурсанцрын үрэвсэл (*Bronchiolitis*)
8. Ларингит-төвөнхийн үрэвсэл (*Laryngitis*)
9. Гуурсан хоолойн багтраа (*Asthma*)
- 10.Хоол боловсруулах тогтолцооны өвчин (*Intestinal diseases*)
- 11.Хеликобактерийн шалтгаант ходоодны архаг үрэвсэл (*Helicobacter Rylori-Associates Gastritis*)
- 12.Шимэгч хорхойтох өвчин (*Parasitic disease*)
- 13.Бөөр шээс дамжуулах замын өвчин (*Kidney and urinary tract disease*)
- 14.Бөөрний тэвшинцрийн үрэвсэл (*Pyelonephritis*)
- 15.Бөөрний түүдгэнцрийн үрэвсэл (*Glomerulonephritis*)
- 16.Шээс дамжуулах замын халдвэр (*Urinary tract infection*)
- 17.Нярайн эмгэг (*Neonatal disorder*)
- 18.Нярайн шарлах өвчин (*Jaundice*)
- 19.Нярайн гэдэсний шархлаат үхжилт үрэвсэл (*Neonatal necrotizing enterocolitis*)
- 20.Мэдрэлийн эмгэг (*Common neurological diseases/*)
- 21.Менингит (*Meningitis*)
- 22.Нүүрний мэдрэлийн захын саа (*Facial nerve paralysis*)
- 23.Хүчилтөрөгч-Цус дуталт тархины эмгэгшил (*Hypoxic ischemic encephalopathy*)
- 24.Эпилепси (*Epilepsy*)
- 25.Менингокоот халдвэр (*Meningococcemia*)
- 26.Улаан эсэргэнэ (*Scarlet fever*)
- 27.Хачигт риккетсиоз (*Rickettsiosis*)
- 28.Улаанбурхан (*Measles*)
- 29.Улаанууд (*Rubella*)
- 30.Салхин цэцэг (*Chicken pox*)
- 31.Гахайн хавдар (*Epidemic parotitis, mumps*)
- 32.Гар, хөл, амны өвчин (*Hand, foot and mouth disease*)

33. Энтеровирусийн халдвар (*Enterovirus infection*)
34. Суулгах хам шинж бүхий халдварууд (*Diarrhea*)
35. Цусан суулга (*Shigellosis*)
36. Сальмонеллёзын халдвар (*Salmonellosis*)
37. Хоолны хордлого (*Food poisoning*)
38. Хавьтад харшлын дерматит (*Allergic dermatitis*)
39. Чонон хөрвөс (*Urticari*)
40. Атопийн дерматит (*Atopic dermatitis*)
41. Шенлейн-Хенохийн өвчин (*Henoch-Schonlein purpura*)
42. Верльгофийн өвчин (*Idiopathic thrombocytopenic purpura*)
43. Яаралтай тусламж шаардлагатай эмгэгүүд (*disorders requiring emergency care*)
44. Эрчимт эмчилгээ шаардлагатай эмгэгүүд (*disorders requiring intensive care*)
45. Мэс засал шаардлагатай эмгэгүүд (*disorders requiring surgery*)
46. Хүүхдийн халдварт өвчин, сүрьеэ (*pediatric infectious disease, tuberculosis*)
47. Өсвөр үеийн эмгэг (*adolescent care*)
48. Сэтгэцийн эмгэг (*psychology*)
49. Арьсны эмгэг (*dermatology*)
50. Харшлын эмгэг (*allergology*)

#### **5.2.4 Гардан үйлдэл (Үйлдлийн олон улсын 9 дүгээр ангиллаар (ICD-9 code)):**

1. Эцэг эх, асран хамгаалагч, хүүхдээс асуумж авах (*take a medical history*)
2. Эрүүл ба эмгэгтэй нярай хүүхдэд үзлэг хийх (*neonates physical examination*)
3. Хөхүүл хүүхдэд үзлэг хийх (*breastfeeding infants physical examination*)
4. Бага насны хүүхдэд үзлэг хийх (*toddlers physical examination*)
5. Өсвөр насны хүүхдэд үзлэг хийх (*teenagers physical examination*) - ICD9 -89.7
6. Антропометрийн хэмжилтүүд (*anthropometry measurements*) - ICD9 – 93.07
7. Амьсгал тоолох (*check breathing rate*)
8. Зүрхний цохилт тоолох (*check hearth rate*)
9. Артерийн даралт үзэх (*check arterial pressure*) – ICD9 – 89.61
10. Жин, өндөр, толгойн тойргийг хэмжих, өсөлтийн муруйд тэмдэглэх (*measure weight, height, head circumference and fill the chart*)- ICD9 – 93.07
11. Лабораторийн шинжилгээний үзүүлэлтүүдийг дүгнэж сурax (*learn evaluate laboratory findings*)
12. Хоол тэжээлийн зөвлөгөө өгөх (*Nutrition advice*)-ICD9-89.08
13. Гуурсаар хооллох (*tube feeding*) - ICD9 -96.6
14. Нярай хүүхдийг жижиг аягаар хооллох (*newborn cup feeding*)-
15. Судсаар тарих (*intravenous injection*)- ICD9 – 99.2
16. Нүд, хамар, чихэнд эм дусаах (*Instilling medication into the eyes, nose, and ears*)
17. Захын судсанд гуурс тавих- ICD9 -
18. Ходоодонд гуурс тавих (*nasogastric tube*) – ICD9 - 96.07
19. Ходоод угаах (*clean stomach with tube*)-ICD9 - 96.33
20. Цөс угаах (*gallbladder lavage*) – ICD9 - 96.41
21. Цөс хаймсуурдах (*gallbladder drainage*)- ICD9 - 96.41

22. Салиа соруулах (*neonatal suction*)
23. Нугасны хатгалт хийх (*lumbar puncture procedure*) – ICD9 - 03.31
24. Төвөнх дурандах (*laryngeal endoscopy*) – ICD9 -31.42
25. Эцэг эх, асран хамгаалагч, хүүхдээс асуумж авах (*take a medical history*)
26. Эрүүл ба эмгэгтэй нярай хүүхдэд үзлэг хийх (*neonates physical examination*) - ICD9- 95.02
27. Нярайд нүдний улаан рефлекс шалгах(*red reflex*)
28. Отоскопоор үзлэг хийх үнэлэлт өгөх (*examination by otoscope*)
29. Цээж,хэвлийн тойм рентген зургийг үнэлэх (*chest, abdomen X ray evaluation*)-ICD9- 87.44 /87.6/
30. Хөхүүл хүүхдэд үзлэг хийх (*breastfeeding infants physical examination*)
31. Бага насын хүүхдэд үзлэг хийх (*toddlers physical examination*)
32. Мөгөөрсөн хоолойд гуурс тавих (*tracheostomy*)- ICD9-31.1
33. Амьсгалыг хүүдий маскаар дэмжих (*rescue breathing with ambu mask*)- ICD9-93.91
34. Зүрхэнд иллэг хийх (*cardiopulmonary resuscitation*)- ICD9- 99.63
35. Хүчинтөрөгч өтгөрүүлэгч ажиллуулагч (*work on oxygen concentrator machine*)-ICD9- 93.96
36. CPAP – аар амьсгалуулах (*give a breath with CPAP machine*)-ICD9-93.90
37. Цээжний хөндийн хатгалт хийх (*punctuation in chest cavity* ) – ICD9 - 34.06
38. Давсаг хаймсуурдах (*urinary catheterization*)-ICD9-59.94
39. Харшлын сорил тавих, үнэлгээ өгөх (*do and evaluate allergy skin test*)- ICD9-99.12
40. Цусны чихрийн хэмжээг тестээр тодорхойлох (*check blood sugar with glucometer*)
41. Цусны бүлэг тодорхойлох (*check blood type*)
42. Цус юулэх, хувийн тохироо үзэх (*check blood group compatibility*) – ICD9 -99.01
43. Хамрын чихээс хийх (*do nasal tamponade*) – ICD9 -97.32
44. Хамар угаах (*nasal irrigation*)-ICD9-96.53
45. Дусал шахагч ажиллуулах (*work on infusion pump*)
46. Пульсоксиметр ажиллуулах (*work on pulse oxymeter*)
47. Бургуй тавих (*use enema*) –ICD9-96.39
48. Гуурсан хоолойн дурангийн шинжилгээнд өвчтөн бэлтгэх (*prepare apatient for an upper endoscopy*)
49. Ходоод, гэдэсний дуранд өвчтөн бэлтгэх (*prepare apatient forgastrointestinal endoscopy* ) - ICD9 -96.39
50. Шээс шинжилгээнд авах (*take an urine for test*)
51. Амьсгалын зам чөлөөлөх энгийн арга (*Manual airway management*)
52. Зүрх уушгини сэхээн амьдруулалт /Нярай, хүүхэд/ (*Cardiopulmonary resuscitation /infant, child/* - ICD9-99.60
53. Цус авах (*Blood drawing*)
54. Тариа хийх /нярай, бага насын хүүхдэд/ (*give an injection to a neonate, child*)- ICD- 99.2
55. Оёдол тавих /цус тогтоох, шарх цэгцлэх (*Suturing /Hemostasis, Wound suturing*) – ICD9 -39.98
56. Хүүхдийн өсөлт хөгжлийн үнэлгээ (*Evaluation of child development*)
57. Ясанд хатгалт хийх (*Bone pricking* ) ICD9- 93.25

58. Интубаци тавих (*intubation*) ICD9- 31.2  
 59. Амьсгалын аппарат ажиллуулах (*ventilator operation*) ICD9- 93.9  
 60. Зүрхний цахилгаан бичлэг хийж дүгнэлт өгөх (*electrocardiogram and giving conclusions*) ICD9- 89.52

### **ЗУРГАА. СУРГАЛТЫН АГУУЛГА**

Сургалт нийт 88 долоо хоног үргэлжлэх ба заавал судлах тойролтуудыг хийж гүйцэтгэсэн байна. Сургалтын 1 дүгээр дамжаанд 44 долоо хоног, 2 дүгээр дамжаанд 44 долоо хоногийн сургалтыг сургалт хариуцсан байгууллагын ментор багш, сургагч багш, мэргэжилтнүүд хариуцан зохион байгуулж үр дүнг сурлагын дэвтэрт тэмдэглэнэ.

#### **Тойролтын хуваарь**

<b>№</b>	<b>Тойролт</b>	<b>Хугацаа</b>	<b>Тойролт явагдах СЭБ</b>
<b>1 дэх жил</b>			
1.	Яаралтай тусламж, эрэмбэлэн ангилалт	4 долоо хоног	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв Монгол Японы эмнэлэг
2.	Хүүхдийн өвчний цогц менежмент Эмнэлзүйн дадлага /амбулаторит/	2 долоо хоног	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв Дүүргүүдийн эмнэлгийн Хүүхдийн тасаг, амбулатори
3.	Амьсгалын эрхтэн тогтолцооны эмгэг	4 долоо хоног	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв Монгол Японы эмнэлэг
4.	Зүрх судасны эрхтэн тогтолцооны эмгэг	4 долоо хоног	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
5.	Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эмгэг	4 долоо хоног	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв Монгол Японы эмнэлэг
6.	Бөөр судлалын эрхтэн тогтолцооны эмгэг	4 долоо хоног	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв Монгол Японы эмнэлэг
7.	Дотоод шүүрлийн эрхтэн тогтолцооны эмгэг	4 долоо хоног	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв Монгол Японы эмнэлэг
8.	Нярай судлал	5 долоо хоног	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв Амаржих газрууд
9.	Харшил судлал	2 долоо хоног	Арьсны өвчин судлалын үндэсний төв
10.	Арьс судлал	2 долоо хоног	Арьсны өвчин судлалын үндэсний төв
11.	Чих хамар хоолойн эмгэг	2 долоо хоног	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв Монгол Японы эмнэлэг
12.	Мэдрэл судлал	4 долоо хоног	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв Монгол Японы эмнэлэг

13.	Хүүхдийн хэвлийн эрхтний яаралтай мэс заслын эмгэг	2 долоо хоног	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв Монгол Японы эмнэлэг
14.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэндийн тусlamж	1 долоо хоног	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах үндэсний төв
<b>Нийт</b>		<b>44 долоо хоног</b>	
<b>2 дахь жил</b>			
1.	Яаралтай тусlamж, сэхээн амьдруулах эрчимт эмчилгээ	4 долоо хоног	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв Монгол Японы эмнэлэг
2.	Амьсгалын эрхтэн тогтолцооны эмгэг	4 долоо хоног	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв Монгол Японы эмнэлэг
3.	Зүрх судасны эрхтэн тогтолцооны эмгэг	4 долоо хоног	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
4.	Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эмгэг	4 долоо хоног	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
5.	Бөөр судлалын эрхтэн тогтолцооны эмгэг	2 долоо хоног	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв Монгол Японы эмнэлэг
6.	Дотоод шүүрлийн эрхтэн тогтолцооны эмгэг	2 долоо хоног	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв Монгол Японы эмнэлэг
7.	Нярай судлал	4 долоо хоног	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв Амаржих газруудын нрайн эмгэгийн тасаг
8.	Цус хавдар судлал	4 долоо хоног	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
9.	Мэдрэл судлал	2 долоо хоног	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
10.	Мэс засал 1 (ерөнхий мэсзасал)	2 долоо хоног	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв Монгол Японы эмнэлэг
11.	Мэс засал 2 /гэмтэл, согог судлал/	1 долоо хоног	Гэмтэл согог судлалын үндэсний төв
12.	Мэс засал 3 /тулэнхий /	1 долоо хоног	Тулэнхийн төв
13.	Дүрс оношилгоо	2 долоо хоног	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв Монгол Японы эмнэлэг
14.	Хүүхдийн халдварт өвчин, сүрьеэ	1 долоо хоног	Халдварт өвчин судлалын үндэсний төв

15.	Дархлаа ревматологи	1 долоо хоног	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
16.	Удамзүй	1 долоо хоног	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв Монгол Японы эмнэлэг
17.	Өсвөр үеийн эрүүл мэнд	2 долоо хоног	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв Монгол Японы эмнэлэг
18.	Нүдний эмгэг, хараа хамгаалал	1 долоо хоног	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
19.	Сэтгэцийн эрүүл мэнд	1 долоо хоног	Сэтгэцийн эмгэг судлалын үндэсний төв
20.	Эмгэг судлал	1 долоо хоног	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв Эмгэг судлалын үндэсний төв Монгол Японы эмнэлэг
<b>Нийт</b>		<b>44 долоо хоног</b>	

## ХИЧЭЭЛИЙН ҮНДСЭН АГУУЛГА:

### Хүүхдийн яаралтай тусламж (тойролт 1-1)

Мэдлэг

- Хүүхдийн эрэмбэлэн ангилах яаралтай тусламж
- Хүнд өвчтөний тээвэрлэлт, шилжүүлэлт
- Гэмтлийн үед үзүүлэх тусламж
- Цус алдалтын цохиулалт, эмчилгээний зарчим
- Ходоод гэдэсний замд хор орсон үед үзүүлэх тусламж
- Арьс болон нүдэнд хор орсон үед үзүүлэх тусламж
- Амьсгалын замаар хор орсон үед үзүүлэх тусламж
- Өвөрмөц хорууд
- Могой, шавьжид хатгуулсан үеийн тусламж
- Золгүй тохиолдлууд (Живэх, цахилгаан гүйдэлд цохиулах, цохих долгионд цохиулах, хөлдөлт, осголт, түлэгдлийн үеийн яаралтай тусламж)

Ур чадвар

- ABCD зарчмыг хэрэгжүүлэх
- Хахсан хүүхдийн хахааг гаргах
- Амьсгалын замыг чөлөөлөх
- Амьсгалыг хүүдий, маскаар дэмжих

- Хүнд тураалтай ба тураалгүй хүүхдэд шокын эсрэг эмчилгээ хийх
- Хүзүү толгойн гэмтэлтэй хүүхдийн тусlamж
- Таталтыг эмчлэх
- Халуун буулгах
- Цусны чихэр хэмжих
- Судсанд болон ясанд хатгалт хийх
- Хүнд өвчтөний тээвэрлэлт, шилжүүлэлт
- Арьс болон нүдэнд хор орсон үед үзүүлэх тусlamж
- Амьсгалын замаар хор орсон үед үзүүлэх тусlamж
- Өвөрмөц хорууд - Могой, шавьжид хатгуулсан үеийн тусlamж
- Золгүй тохиолдлууд (Живэх, цахилгаан гүйдэлд цохиулах, цохих долгионд цохиулах
- Өвчтэй хүүхэд, түүний эх, эцэгтэй харьцах, зөвлөгөө өгөх
- Бусад эмч, сувилагч нартай багаар ажиллах
- Сурганы ур чадвар: эмч, сувилагчдад сургалт явуулахад оролцох

#### Хандлага

- ABCD зарчмыг чанд баримтлах
- Тусlamж үзүүлэхээс өмнө бичиг баримт шаардахгүй байх
- Эх, эцэгт хүүхдийн хүүхдийн өвчний тухай ойлгуулах
- Хүүхдийн тусlamжийг сайжруулахтай холбоотой гарч буй өөрчлөлтийг дэмжих

#### **ХӨЦМ, бага насны хүүхдийн суурь эмгэг (тойролт 1-2)**

#### Мэдлэг

- Өвчтэй хүүхдийг оношлох арга барил
- Хүүхдийн дэмжих эмчилгээ, биеийн байдлыг өөрчлөлтийг хянах
- Сульдаа өвчин, шалтгаан, эмгэг жам, ангилал, эмнэл зүй, оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт
- Тураал, шалтгаан, эмгэг жам, ангилал, эмнэл зүй, оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт
- Шүүдэст эмзэгшил, тунгалаг төлжилт доройтол, харшлын эмгэгшлийн шалтгаан, эмгэг жам, ангилал, эмнэл зүй, оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт

- Бодис дутлын шалтгаант цус багадалт, шалгаан, эмгэг жам, ангилал, эмнэл зүй, оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт
- ХӨЦМ
- Бие галбирын гаж эмзэгшлүүд

#### Ур чадвар

- Амьсгал тоолох
- Тав хүртэлх насын өвчтэй хүүхдэд эмнэлзүйн үзлэг хийх
- Амьсгалын замын цочмог халдвартыг эмчлэх
- Суулгалт өвчнийг А, Б, В төлөвлөгөөгөөр эмчлэх
- Хүүхдийн суурь эмгэгтэй хүүхдийг эмчлэх
- Нярайн эмгэгийг эмчлэх
- ХӨЦМ-д заагдсан бусад өвчнийг эмчлэх
- Сульдаа, цус багадалт, тураалаас сэргийлэх
- Нэмэгдэл хоолонд зөв оруулах
- Тураалтай хүүхдийн хоолны тооцоо хийх
- Эрүүл ба өвчтэй хүүхдийн эх, эцэгтэй харьцах, зөвлөгөө өгөх
- Гэртээ эм уулгах, хэсэг газрын эмчилгээг хэрхэн хийх тухай эхэд заах
- Бусад мэргэжлийн эмч настай хамтран ажиллах
- Эмч, сувилагчдад сургалт явуулах

#### Хандлага

- Эх, эцэгт хүүхдийн асаргаа сувилгаа, хөхөөр хооллолт, цаг алдалгүй тусlamж хийх мэдлэгийн талаар ойлгуулах
- Хүүхдийн биеийн байдлыг хянах
- Эхийг урамшуулан магтах, мэдлэгийг шалгах
- Эхэд зөвлөгөө өгөх 4 зарчмыг ямагт баримтлах
- Хүүхдийн тусlamжийг сайжруулахтай холбоотой гарч буй өөрчлөлтийг дэмжих

#### **Хүүхдийн амьсгалын замын эрхтний эмгэг судлал (тойролт 1-3, 2-2)**

##### Мэдлэг

- Хүүхдийн амьсгалын эрхтний бүтэц, үйл ажиллагааны онцлог

- Амьсгалын замын эрхтнийг шинжлэх, бодит үзлэг, үнэлгээ өгөх
- Амьсгалын замын өвчний үеийн шинж тэмдэг, хамшинжүүд, үнэлэх
- Амьсгалын дээд замын цочмог халдвартууд, шалтгаан, ангилал
- Эмгэгжам, эмнэлзүй, оношлогоо, эмчилгээ, сэргийлэлт
- Төвөнх, мөгөөрсөн хоолойн үрэвсэл, эмнэлзүй, эмчилгээ, сувилгаа
- Хяхтнаа амьсгалтай хүүхэд, эмчилгээ
- Гуурсан хоолойн цочмог үрэвсэл, эмнэлзүй, эмчилгээ, сувилгаа
- Шуугиантай амьсгалтай хүүхэд, эмчилгээ
- Гуурсанцрын үрэвсэл, үзлэг, эмчилгээ, сувилгаа
- Уушгини цочмог үрэвсэл, үзлэг, эмчилгээ, сувилгаа
- Гуурсан хоолойн архаг үрэвсэл, үзлэг, эмчилгээ, сувилгаа
- Гуурсан хоолойн архаг бөглөршилт үрэвслийн үзлэг, эмчилгээ, сувилгаа
- Архаг ханиалгалт, эмчилгээ
- Уушгини гялтангийн үрэвсэл, оношлогоо, эмчилгээ
- Амьсгалын замын өвчтэй хүүхдэд хэрэглэх эмийн клиник фармакологи
- Амьсгалын эрхтний өвчтэй хүүхдийн эцэг, эхэд зөвөлгөө өгөх, диспансерийн хяналт
- Хүүхдийн бие галбирын гаж төлөв, тураал, цус багадалт, сульдаа өвчтэй хүүхдийн уушгини хатгалгааны онцлог
- Цочмог суулгалт

#### Ур чадвар

- Амьсгалын эрхтний эмгэгтэй хүүхдэд эмнэлзүйн үзлэг хийх
- Хяхтнаа амьсгалтай хүүхдийг эмчлэх
- Шуугиантай амьсгалыг нейбулазороор эмчлэх
- Хамар угаах
- Хүчилтөрөгч эмчилгээ хийх
- Цээжний хөндийн хатгалт хийх
- Хураагуур судсанд катетр тавих, дусал эмчилгээ хийх
- Цусны дэлгэрэнгүй, биохими, иммунологи, нян судлал, серологи зэрэг хүүхдэд элбэг хийгддэг шинжилгээг бичих, тэдгээрт гарсан өөрчлөлтийг илрүүлэх
- Цээжний рентген зураг унших

- Амьсгалын дасгал заах, физик эмчилгээ хийх
- Өвчтэй хүүхдийн эх, эцэгтэй харьцах, зөвлөгөө өгөх
- Бусад мэргэжлийн эмч, сувилагч нартай хамтран ажиллах
- Сурганы ур чадвар: эмч, сувилагчдад сургалт явуулахад оролцох

#### Хандлага

- Эх, эцэгт хүүхдийн асаргаа сувилгаа, цаг алдалгүй тусlamж хайх мэдлэгийн талаар ойлгуулах
- Эхийг урамшуулан магтах, мэдлэгийг шалгах
- Эхэд зөвлөгөө өгөх 4 зарчмыг ямагт баримтлах
- Хүүхдийн тусlamжийг сайжруулахтай холбоотой гарч буй өөрчлөлтийг дэмжих

#### **Хүүхдийн зүрх судас, холбогч эдийн эмгэг (тойролт 1-4, 2-3)**

##### Мэдлэг

- Хүүхдийн зүрх судасны эрхтэн тогтолцооны онцлог
- Зүрх судасны эмгэгийг шинжлэх инвазив ба инвазив бус арга
- Хүүхдийн зүрхний цахилгаан бичлэгийн онцлог, хийх техник
- Зүрхний төрөлхийн гажиг: ховдол хоорондын таславчийн цоорхой
- Зүрхний төрөлхийг гажиг: тосгуур хоорондын таславчийн цоорхойн оношлогоо, менежмент
- Зүрхний төрөлхийн гажиг: Артерийн битүүрээгүй цорго оношлогоо, эрт эмийн эмчилгээний менежмент
- Зүрхний төрөлхийн хөх гажгууд оношлогоо, менежмент
- Хэрлэг өвчний шалтгаан, ангилал, эмгэгжам, эмнэлзүй, оношлогоо, эмчилгээ, сэргийлэлт
- Хэрлэгийн гаралтай хавхлагийн гажгийн оношлогоо, гемодинамикийн онцлогууд
- Хэрлэгийн бус шалтгаант зүрхний үрэвсэл
- Зүрхний хэм алдагдлууд, ялган оношлогоо, эмчилгээ
- Зүрх судасны эмгэгийн яаралтай тусlamж
- Холбогч эдийн эмгэгүүд ялган оношлогоо, эмчилгээ, менежмент
- Зүрхний гялтан хальсны үрэвсэл, шалтгаан, ангилал, эмгэгжам, эмнэлзүй, оношлогоо, эмчилгээ, сэргийлэлт
- Зүрхний дутагдал

- Артерийн даралт ихсэх багасах шалтгаан, эмгэгжам, цус хөдлөх зүй, эмнэлзүй, эмчилгээ, сэргийлэлт
- Геморрагический васкулит оношлогоо, эмчилгээ
- Хэрэх төст үенний үрэвсэл
- Чонон яр
- Зүрх судасны өвчний клиник фармакологи, диспансерийн хяналт

#### Ур чадвар

- Зүрхний эмгэгтэй хүүхдэд эмнэлзүйн үзлэг хийх
- Зүрхний цахилгаан бичлэг хийх
- Зүрхний хэм алдалтыг эмчлэх
- Зүрхний төрөлхийн гажгийг эрт илрүүлэх
- Зүрхний эхо шинжилгээнд өвчтөн бэлтгэх
- Цусны дэлгэрэнгүй, биохими, иммунологи, нян судлал, серологи зэрэг хүүхдэд элбэг хийгддэг шинжилгээг бичих, тэдгээрт гарсан өөрчлөлтийг илрүүлэх
- Зүрхний мэс засал хийлгэсэн хүүхдийг хянах
- Өвчтэй хүүхдийн эх, эцэгтэй харьцах, зөвлөгөө өгөх
- Бусад мэргэжлийн эмч, сувилагч наратай хамтран ажиллах
- Сурганы ур чадвар: эмч, сувилагчдад сургалт явуулахад оролцох

#### Хандлага

- Эх, эцэгт хүүхдийн зүрхний гажгийн тухай ойлгуулах
- Эхийг урамшуулан магтах, мэдлэгийг шалгах
- Эхэд зөвлөгөө өгөх 4 зарчмыг ямагт баримтлах
- Хүүхдийн тусламжийг сайжруулахтай холбоотой гарч буй өөрчлөлтийг дэмжих

#### **Хүүхдийн хоол боловсруулах эрхтний эмгэг судлал (тойролт 1-5, 2-4)**

#### Мэдлэг

- Хоол боловсруулахын эмгэгтэй өвчтөнд хийх үзлэг ба шинжилгээ
- Хүүхдийн хоол боловсруулах эрхтний анатом, физиологийн онцлог
- Амны хөндий, улаан хоолойн өвчний оношлогоо, эмчилгээ
- Ходоодны цочмог үрэвсэл, шалтгаан, ангилал, эмнэлзүй, оношлогоо, эмчилгээ.
- Эмийн гастрит
- Ходоодны архаг үрэвсэл, шалтгаан, ангилал, эмнэлзүй, оношлогоо, эмчилгээ

- Ходоод, 12 хуруу гэдэсний шархлаа, оношлогоо, эмчилгээ, хяналт
- Хоол боловсруулах эрхтний эмгэгийн яаралтай тусlamж (өвдөлт, цус алдалт зэрэг)
- Ужиг суулгалт
- Хүнд тураал, эмчилгээ
- Нарийн гэдэсний архаг үрэвсэл
- Шимэгдэлт буурах хамшинжийн оношлогоо, эмчилгээ
- Гэдэсний нянгийн бичил орчны өөрчлөлт
- Бүдүүн гэдэсний өвөрмөц бус үрэвсэл
- Архаг өтгөн хаталт (долихосигма, Гришпрунгийн өвчин)
- Элэгний архаг үрэвсэл, шалтгаан, ангилал, эмгэгжам, эмнэлзүй, оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт
- Элэгний цирроз, элэгний дутагдал, шалтгаан, ангилал, эмгэгжам, эмнэлзүй, оношлогоо, эмчилгээ, сэргийлэлт
- Цөсний цочмог үрэвсэл, шалтгаан, ангилал, эмгэгжам, эмнэлзүй оношлогоо, эмчилгээ, сэргийлэлт
- Цөсний үйлийн хямрал, шалтгаан, ангилал, эмгэгжам, эмнэлзүй, оношлогоо, эмчилгээ, сэргийлэлт
- Цөсний чулуу, шалтгаан, ангилал, эмгэгжам, эмнэлзүй, оношлогоо, эмчилгээ, сэргийлэлт
- Цөсний архаг үрэвсэл эмчилгээ
- Шарлах хамшинж
- Нойр булчирхайн үрэвсэл
- ХБЗ-ын өвчний үеийн хоол эмчилгээ
- Шимэгч хорхойн тухай ойлголт, хялгасан, хуж ба тузан хорхой, оношлогоо, эмчилгээ
- ХБЗ-ын эмгэгийн клиник фармакологи, диспансерийн хяналт

#### Ур чадвар

- ХБЭ-ний эмгэгтэй хүүхдэд эмнэлзүйн үзлэг хийх
- Ужиг суулгалтыг эмчлэх
- Хүнд тураалыг эмчлэх

- Хоол боловсруулах эрхтний эмгэгийн яаралтай тусламж үзүүлэх (өвдөлт, цус алдалт зэрэг)
- Ходоод хаймсуурдах
- Ходоод угаах
- Цөс хаймсуурдах
- Цусны дэлгэрэнгүй, биохими, иммунологи, нян судлал, серологи зэрэг хүүхдэд элбэг хийгддэг шинжилгээг бичих, тэдгээрт гарсан өөрчлөлтийг илрүүлэх
- Өвчтэй хүүхдийн эх, эцэгтэй харьцах, зөвлөгөө өгөх
- Бусад мэргэжлийн эмч, сувилагч нартай хамтран ажиллах
- Сурганы ур чадвар: эмч, сувилагчдад сургалт явуулахад оролцох

#### Хандлага

- Эх, эцэгт хүүхдийн асаргаа сувилгаа, хөхөөр хооллолт, цаг алдалгүй тусламж хайх мэдлэгийн талаар ойлгуулах
- Эхийг урамшуулан маттах, мэдлэгийг шалгах
- Эхэд зөвөлгөө өгөх 4 зарчмыг ямагт баримтлах
- Өсвөр насныхантай нууцыг хадгалах зарчмыг баримтлан харьцах
- Хүүхдийн тусламжийг сайжруулахтай холбоотой гарч буй өөрчлөлтийг дэмжих

#### **Бөөр, шээсний замын эмгэгүүд (тойролт 1-6, 2-5)**

#### Мэдлэг

- Хүүхдийн бөөрний анатом, физиологийн онцлог
- Бөөрний үйл ажиллагааг шинжлэх аргууд
- Бөөрний өвчний үед илрэх шинж тэмдэгүүд ба хамшинжүүд
- Цочмог, архаг пиелонефрит шалтгаан, ангилал, эмгэгжам, эмнэлзүй, оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт
- Цочмог, архаг гломерулонефрит шалтгаан, ангилал, эмгэгжам, эмнэлзүй, оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт
- Бөөрний цочмог, архаг дутагдал, шалтгаан, ангилал, эмгэгжам, эмнэлзүй, оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт
- Бөөрний завсрын эдийн үрэвсэл
- Цусархаг эмзэгшлийн нефропати
- Бөөрний сүрьеэ

- Цочмог, архаг цистит шалтгаан, эмгэгжам, эмнэлзүй, оношлогоо, эмчилгээ, сэргийллэлт
- Бөөрний гаж хөгжил, Фанкони
- Нефроптоз.
- Бөөрний өвчтэй хүүхдэд шатчилсан тусlamж, диспансерийн хяналт
- Бөөрний өвчтэй хүүхдийн сувилал, сувилахуй, хоол эмчилгээ
- Бөөр шээсний замын өвчинд өргөн хэрэглэх эмийн кли.фармаколог

Ур чадвар

- Бөөрний эмгэгтэй хүүхдэд эмнэлзүйн үзлэг хийх
- Хүүхдийн биеийн жин хэмжих
- Хүүхдийн даралт хэмжих
- Шинжилгээнд өвчтөн бэлтгэх
- Бүх төрлийн шээсний шинжилгээ авах, дүгнэлт хийх
- Цусны дэлгэрэнгүй, биохими, иммунологи, нян судлал, серологи зэрэг хүүхдэд элбэг хийгддэг шинжилгээг бичих, тэдгээрт гарсан өөрчлөлтийг илрүүлэх
- Цистограмм хийх
- Давсагт гуурс тавих
- Өвчтэй хүүхэд, түүний эх, эцэгтэй харьцах, зөвлөгөө өгөх
- Бусад мэргэжлийн эмч, сувилагч наортай хамтран ажиллах
- Сурганы ур чадвар: эмч, сувилагчдад сургалт явуулахад оролцох

Хандлага

- Эх, эцэгт хүүхдийн хүүхдийн өвчний тухай ойлгуулах
- Хүүхдийн тусламжийг сайжруулахтай холбоотой гарч буй өөрчлөлтийг дэмжих

### **Хүүхдийн дотоод шүүрлийн булчирхайн эмгэгүүд (тойролт 1-7, 2-6)**

Мэдлэг

- Бие бялдрын хөгжлийн үнэлгээ, илрэх эмгэгийн ялган оношлогоо
- Хүүхдийн дотоод шүүрлийн булчирхайн анатом, физиологийн онцлог
- Чихрийн шижин, эрт, хожуу үеийн хүндрэлүүд, оврого
- Чихрийн бус шижин
- Хордлогот бахлуур

- Гипотиреоз
- Иод дутагдлын эмгэг
- Таргалалтууд
- Гинекомасти
- Хүүхдийн бэлгийн бойжилтын хямралууд
- Гипогонадизм
- Сэрээ булчирхайн эмгэг
- Иценко-Кушингийн өвчин, хамшинж
- Бөөрний дээд булчирхайн эмгэгүүд, төрөлхийн үйлийн хямрал, гипергипокортицизм, яланг оношлогоо
- ДШЭ-ийн үеийн эмийн фармакологи, диспансерийн хяналт

Ур чадвар

- Дотоод шүүрлийн эмгэгтэй хүүхдэд эмнэлзүйн үзлэг хийх
- Цус, шээсэнд сахар тодорхойлох
- Инсулин эмчилгээ
- Хүүхдийн бие бялдрын хөгжлийг үнэлэх
- Хүүхдийн бэлгийн бойжилтыг үнэлэх
- Цусны дэлгэрэнгүй, биохими, иммунологи, нян судлал, серологи зэрэг хүүхдэд элбэг хийгддэг шинжилгээг бичих, тэдгээрт гарсан өөрчлөлтийг илрүүлэх
- Өвчтэй хүүхэд, түүний эх, эцэгтэй харьцах, зөвлөгөө өгөх
- Бусад мэргэжлийн эмч, сувилагч наортай хамтран ажиллах
- Сурганы ур чадвар: эмч, сувилагчдад сургалт явуулахад оролцох

Хандлага

- Эх, эцэгт хүүхдийн хүүхдийн өвчний тухай ойлгуулах
- Хүүхдийн тусlamжийг сайжруулахтай холбоотой гарч буй өөрчлөлтийг дэмжих

### **Нярай судлал (тойролт 1-8, 2-7)**

Мэдлэг

- Нярайн тусlamжийн зохион байгуулалт, шатчилал, одоогийн байдал, халдварт хамгааллын дэглэм, нярайн нэр томьёонууд, дүн бүртгэлийн үзүүлэлтүүд
- Нярайн эрүүл эмгэгийн зааг байдлууд, гүйцэт нярайн онцлог, хооллолт, хоолны тооцоо

- Дутуу ба бага жинтэй нярайн онцлог, асаргаа сувилгаа, хооллох арга
- Нярайн нэн шаардлагатай тусламж
- Нярайн анхдагч сэхээн амьдруулалт хүнд болон хүндэвтэр бүтэлтийн үед авах арга хэмжээ, амьсгалын зам чөлөөлөх, зохиомол амьсгал хийх, зүрхэнд шууд бус массаж хийх, хүйн судсаар эмчилгээ хийх, нярай хүүхдэд эрчимт эмчилгээ хийх/
- Ураг ба нярайн бүтэлт, шалтгаан, ангилал, эмгэгжам, эмнэлзүй, оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт
- Нярайн амьсгал хямралын хамшинж, шалтгаан, ангилал, эмгэгжам, эмнэлзүй, оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт
- Нярайн дулаан зохицуулга, гипо-гипертерми, нярайг тээвэрлэх зарчим, нярайн цусны чихэр багадалт
- Нярайн цусны кальци, кали, магнийн тэнцэл, шалтгаан, эмнэлзүй, оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт
- Нярайн тархины эмгэгшлийн шалтгаан, ангилал, эмгэгжам, эмнэлзүй, оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт
- Нярайн уушгини хатгалгаа, шалтгаан, эмнэлзүй, оношлогоо, эмчилгээ
- Нярайн цусархаг хамшинж, шалтгаан, эмнэлзүй, оношлогоо, эмчилгээ
- Нярайн шарлалт, ангилал, эмнэлзүй, оношлогоо, эмчилгээ
- Нярайн халдварын гаралтай өвчинүүд, үжил, шалтгаан, ангилал, эмгэгжам, эмнэлзүй, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт
- Нярайн тандалт шинжилгээ
- Нярайд хэрэглэх эмийн клиник фармакологи

#### Ур чадвар

- Нярайн сэхээн амьдруулалт, мөгөөрсөн хоолойд гуурс тавих, зохиомлоор амьсгал удирдах
- Хүйн болон хураагуур судсанд катетр тавих, дусал эмчилгээ хийх
- Цус сэлбэх, цус солих эмчилгээ
- Артерийн судас, плеврийн хөндий, давсганд хатгалт хийх, нугасны ус авах, тархины ховдолд хатгалт хийх
- Цусны дэлгэрэнгүй, биохими, иммунологи, нян судлал, серологи зэрэг нярай хүүхдэд элбэг хийгддэг шинжилгээг бичих, тэдгээрт гарсан өөрчлөлтийг илрүүлэх
- Нярайн цээж, хэвлийн хөндий, үе мөчний зэрэг рентген зураг унших
- Толгой, хэвлийн хөндийн эрхтэнд хийгдсэн хэт авиан шинжилгээг тайлбарлах

- Эрүүл ба өвчтэй нярайд эмнэл зүйн үзлэг хийх, төрөлхийн гаж хөгжил болон бусад өөрчлөлтийг эрт илрүүлэх
- Эрүүл ба өвчтэй нярайн эх, эцэгтэй харьцах, зөвлөгөө өгөх
- Бусад мэргэжлийн эмч нартай хамтран ажиллах
- Нярайн эмч нь инкубатор, дулаацуулагч ширээ, амьсгалын аппарат, монитор, дуслын шахуурга зэрэг тоног төхөөрөмжийн талаар үндсэн мэдлэгтэй байна
- Сурганы ур чадвар: эмч, сувилагчдад сургалт явуулахад оролцох

#### Хандлага

- Хүүхэд төрөхөд ээлтэй орчин бүрдүүлэх, эх үрийн холбоог бэхжүүлэхийг сайтар дэмжих
- Эх, эцэгт нярай хүүхдийн асаргаа сувилгаа, хөхөөр хооллолт, цаг алдалгүй тусlamж хайх мэдлэгийн талаар ойлгуулах
- Нярайн тусlamжийг сайжруулахтай холбоотой гарч буй өөрчлөлтийг дэмжих

#### Харшил (тойролт 1-9)

##### Мэдлэг

- Харшлын өвчний орчин үеийн ойлголт, оношлогоо, анамнез авах - Харшлын сорил, үнэлэх
- Багтраа өвчин шалтгаан, эмгэгжам, эмнэлзүй, оношлогоо, эмчилгээ
- Ургамлын харшил, оношлогоо, эмчилгээ
- Харшилт хавагнашил, шүүдэст эмзэгшил, хүүхдийн намарс
- Эм, хоолны харшил
- Анафилакси, сийвэнгийн харшилт хамшинжүүд
- Стивенс - Джонсоны ба Лайелын хамшинжүүд
- Харшлын өвчний үеийн клиник фармакологи, диспансерийн хяналт

##### Ур чадвар

- Харшлын сорил тавих, дүгнэх
- Багтраат байдлыг эмчлэх, хянах
- Өвчтэй хүүхдийн эх, эцэгтэй харьцах, зөвлөгөө өгөх

#### Хандлага

- Эх, эцэгт хүүхдийн харшлын өвчний тухай ойлгуулах
- Хүүхдийн тусlamжийг сайжруулахтай холбоотой гарч буй өөрчлөлтийг дэмжих

## **Арьс судлал (тойролт 1-10)**

### **Мэдлэг**

- Арьсны өвчинүүд, тархалт, шалтгаан, ангилал, эмгэгжам, эмнэлзүй, оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт
- Тууралтат өвчинүүдийн ялган оношлогоо
- Арьсны өвчний үеийн эмчилгээ, диспансерийн хяналт

### **Ур чадвар**

- Тууралтат өвчинүүдийг ялган оношлох
- Арьсны эмгэгтэй хүүхдийн тусламж
- Цусны дэлгэрэнгүй, биохими, иммунологи, нян судлал, серологи зэрэг хүүхдэд элбэг хийгддэг шинжилгээг бичих, тэдгээрт гарсан өөрчлөлтийг илрүүлэх
- Өвчтэй хүүхдийн эх, эцэгтэй харьцах, зөвлөгөө өгөх

### **Хандлага**

- Эх, эцэгт хүүхдийн асаргаа сувилгааны талаар зөвлөх
- Хүүхдийн тусламжийг сайжруулахтай холбоотой гарч буй өөрчлөлтийг дэмжих

## **Чих хамар хоолойн зонхилон тохиолдох өвчинүүд (тойролт 1-11)**

### **Мэдлэг**

- Хамрын хөндийн эмгэг, архаг үрэвсэл
- Хамрын цус гоожилт
- Залгиурын эмгэг, архаг үрэвслүүд
- Дунд чихний үрэвсэл, түүний хүндрэлүүд
- Чихний үүсэлтэй гавлын хүндрэл
- Чихний хөхөнцирийн хүндрэл
- Төвөнх цагаан мөгөөрсөн хоолойн эмгэг
- Дотор чихний хүндрэл, дүлийрэлт

### **Ур чадвар**

- Мэс засал хийлгэсэн хүүхдийн асаргаа, хяналт
- Хэнгэрэг нөхөх, гүйлсэн булчирхай авах хагалгаанд өвчтөн бэлтгэх
- Хамрын цус алдалтыг тогтоох
- Хамар, чихнээс гадны биет авах

- Өвчтэй хүүхдийн эх, эцэгтэй харьцах, зөвлөгөө өгөх
- Бусад мэргэжлийн эмч, сувилагч нартай хамтран ажиллах

Хандлага

- Эх, эцэгт хүүхдийн асаргаа, сувилгааны талаар зөвлөх

### **Мэдрэлийн эмгэгүүд (тойролт 1-12, 2-9)**

Мэдлэг

- Рефлекс, түүний үүрэг, шалгах арга
- Бага насны хүүхдийн хөдөлгөөн сэтгэцийн үе шат, мэдрэл зүйн үзлэг хийх арга онцлог
- Хүүхдийн тархины саа өвчин шалтгаан, эмнэлзүйн хэлбэрүүд, оношлогоо, эмчилгээ
- Хүүхдийн тархи усжих шалтгаан, эмнэлзүй, оношлогоо, эмчилгээ
- Перинаталь үеийн тархины эмгэг, тархины хүчилтэрөгчийн хурц ба архаг дутагдал, цусан хангамжийн шалтгаан, эмнэлзүйн хэлбэр, оношлогоо, эмчилгээ
- Бичил толгой, краниостеноз эмнэлзүйн шинж, оношлогоо, ялган оношлогоо, эмчилгээ
- Бага насны хүүхдийн уналт таталтын хамшинж шалтгаан, эмчилгээ
- Энцефалопати шалтгаан, эмгэгжам, ангилал, эмнэлзүй, оношлогоо, эмчилгээ, сэргийлэлт
- Мэнэн ангилал, шалтгаан, эмнэлзүй, оношлогоо, эмчилгээ
- Эпилепси ангилал, шалтгаан, эмнэлзүй, оношлогоо, эмчилгээ
- Захын мэдрэлийн эмгэгүүд, нүүрний мэдрэлийн саажилт
- Вегетатив мэдрэлийн тогтолцооны гэмтлийн хам шинжүүд, шалтгаан, эмгэгжам, эмнэлзүй, оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт
- Мэдрэлийн үеийн эмийн фармакологи, диспансерийн хяналт

Ур чадвар

- Хүүхдэд мэдрэлийн үзлэг хийх
- Рефлекс шалгах
- Нугасны усны шинжилгээ авах
- Таталтын эсрэг эмчилгээ хийх
- Тархины цахилгаан бичлэг, зулайн эхо, КТГ-д өвчтөн бэлтгэх
- Хүүхдийн бие бялдрын хөгжлийг үнэлэх

- Цусны дэлгэрэнгүй, биохими, иммунологи, нян судлал, серологи зэрэг хүүхдэд элбэг хийгддэг шинжилгээг бичих, тэдгээрт гарсан өөрчлөлтийг илрүүлэх
- Сэргээн засах эмчилгээ хийх
- Өвчтэй хүүхэд, түүний эх, эцэгтэй харьцах, зөвлөгөө өгөх
- Бусад мэргэжлийн эмч, сувилагч наrtай хамтран ажиллах
- Сурганы ур чадвар: эмч, сувилагчдад сургалт явуулахад оролцох

#### Хандлага

- Эх, эцэгт хүүхдийн хүүхдийн өвчний тухай ойлгуулах
- Хүүхдийн тусламжийг сайжруулахтай холбоотой гарч буй өөрчлөлтийг дэмжих

#### **Мэс заслын зонхилон тохиолдох өвчинүүд (тойролт 1-13, 2-10,2-11,2-12)**

#### Мэдлэг

- Хүүхдийн мэс заслын өмнөх болон дараах асаргаа
- Нярай үед үүсдэг эмгэгүүд
- Хэвлийн хөндийн өвчинүүд
- Хүүхдэд зонхилон тохиолдох шЯЗ-ын эмгэгүүд
- Мэс ажилбар шаардлагатай халдвартуд
- Уруул тагнайн сэтэрхий, короткий язычок
- Тулгуур эрхтний төрөлхийн гажгууд
- Хүүхдэд тохиолдох бусад мэс заслын эмгэгүүд, ахуйн гэмтэл

#### Ур чадвар

- Мэс засал хийлгэсэн хүүхдийн асаргаа, хяналт
- Нярайн мэс заслын эмгэгт анхан шатны тусламж үзүүлэх
- Мэс заслын цочмог халдвартыг оношлох
- Ахуйн гэмтлийн үед тусламж үзүүлэх
- Өвчтэй хүүхдийн эх, эцэгтэй харьцах, зөвлөгөө өгөх
- Бусад мэргэжлийн эмч, сувилагч наrtай хамтран ажиллах

#### Хандлага

- Эх, эцэгт хүүхдийн асаргаа, сувилгааны талаар зөвлөх
- Хүүхдийн осол гэмтлээс сэргийлэх

#### **Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэндийн тусламж (Тойролт 1-14)**

## Мэдлэг

- Бага насны хүүхдийн хөдөлгөөн сэтгэцийн үе шат, мэдрэл зүйн үзлэг хийх арга онцлог
- Хүүхдийг хөгжлийн бэрхшээлд хүргэж болох хөдөлгөөн, сэтгэц, хэл ярианы хоцрогдлыг илрүүлэх аргачлал
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эмнэлгийн тусlamж үйлчилгээ, диспансерийн хяналт

## Ур чадвар

- Хүүхдэд хөдөлгөө сэтгэцийн хоцрогдол илрүүлэх үзлэг хийх
- Хүүхдийн бие бялдрын хөгжлийг үнэлэх
- Сэргээн засах эмчилгээ хийх
- Өвчтэй хүүхэд, түүний эх, эцэгтэй харьцах, зөвлөгөө өгөх
- Бусад мэргэжлийн эмч, сувилагч наrtай хамтран ажиллах
- Сурган заах аргын ур чадвар: эмч, сувилагчдад сургалт явуулахад оролцох

## Хандлага

- Эх, эцэгт хүүхдийн хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн тухай ойлгуулах
- Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн үеийн тусlamжийг сайжруулахтай холбоотой гарч буй өөрчлөлтийг дэмжих

## Сэхээн - амьдруулах эрчимт эмчилгээ (тойролт 2-1)

### Мэдлэг

- Хүүхдийн сэхээн амьдруулах тасгийн зохион байгуулалт, өвчтөн авч, эмчлэх заалт
- Амь тэнссэн төлвийн анагаахын ойлголт, сэхээн амьдруулах эрчимт эмчилгээний үндсэн зарчим
- Амьсгал дэмжих, орлуулах эмчилгээний зарчим.
- Хүчилтөрөгчийн бортого, өтгөрүүлэгчтэй ажиллах зарчим
- Амьсгалын замыг чөлөөлөх.
- Эрэг даралтаар амьсгал дэмжих (өөрөө тэлэгддэг хүүдий болон урсалаар тэлэгддэг хүүдийгээр дэмжих)
- Зүрхний иллэг
- Дефибрилятор хэрэглэх зарчмууд
- Цагаан мөгөөрсөн хоолойд гуурсны тавих, гуурсны асаргаа сувилгаа

- Сэхээн амьдруулалтын үеийн эмийн хэрэглээ
- Сэхээн амьдруулалтын үед ба дараа гарч болох хүндрэлүүд, хяналт
- Сэхээн амьдруулалтын үеийн ёсзүйн асуудлууд
- Гуурсан хоолойн агчил давамгайлсан амьсгалын дутал
- Бронхиолит
- Гуурсан хоолойн багтраат байдлын оношилгоо, эмчилгээ
- Гуурсан хоолойн бөглөршил давамгайлсан амьсгалын дутал.
- Төвөнхийн бачуурал
- Уушгины хатгалгааны эрчимт эмчилгээний зарчим
- Амьсгалыг аппаратаар удирдах өрөнхий зарчим
- Цус эргүүллийн тогтолцооны хямралын хэлбэрүүд
- Зүрхний титэм судасны хомсдол, ховдлын цус хөөлт хомсдол.
- Зүрхний хэм хэт түргэссэн үеийн эмчилгээний зарчим
- Хүчил шүлт, хийн тэнцвэрлэмж
- Орчих цус хомсдлын цохиулалт.
- Хүнд хэлбэрийн шингэн алдалтын үеийн эмчилгээний зарчим
- Бичил судсанд цус нилэнхүй бүлэгнэх хам шинж.
- Бөөрний дээд булчирхайн хурц дутал, эмчилгээний зарчим (Уэтерхауз-Фридрихсений хам шинж)
- Харшил урвалын цохиулалт, эмчилгээний зарчим
- Үжил, үжлийн цохиулалт (Cava сепсис)
- Гавлын дотоод даралт ихдэлтийн менежмент
- Тархинд цус харвалтын үеийн яаралтай тусlamж, эмчилгээний зарчим
- Идээт мэнэнгийн үеийн яаралтай тусlamж, эмчилгээний зарчим
- Эрчимт эмчилгээнд хийгдэх ажилбарууд, хүндрэл, яаралтай тусlamж
- Таталтын хамшинж, эмчилгээний зарчим
- Осол гэмтэл, золгүй тохиолдлын үед үзүүлэх яаралтай тусlamж
- Цочмог хордолт, зонхилох шалтгаан, үзүүлэх яаралтай тусlamж
- Зүрхний бус шалтгаант уушгины хаван
- Бөөрний цочмог дутмагшлын оношлогоо эмчилгээний зарчим

## Үр чадвар

- Амьсгалын замыг чөлөөлөх, амьсгалын замын шулуун байрлалд оруулах
- Амьсгалыг аппаратаар удирдах
- Цагаан мөгөөрсөн хоолойд гуурс тавих
- Мөгөөрсөн хоолой угаах, арчлах
- Пульсоксиметртэй ажиллах
- ABCD зарчмыг хэрэгжүүлэх
- Зүрхэнд шууд бус иллэг хийх, зүрхний иллэгийг эерэг даралтат амьсгалтай хослуулах
- Ларингоскопитой ажиллах, цагаан мөгөөрсөн хоолойд гуурс тавих
- Хүчилтөрөгч өтгөрүүлэгчтэй ажиллах
- Бортоготой хүчилтөрөгчтэй ажиллах
- Хамрын ац гуурсаар хүчилтөрөгч өгөх
- Хамрын гуурсаар хүчилтөрөгч өгөх
- Хамрын залгиурын гуурсаар хүчилтөрөгч өгөх
- Автомат тариур шахагчтай ажиллах
- Автомат тариур шахагчаар допамин эмчилгээ хийх
- Хураагуур судсанд уян зүү тавих
- Эгмийн доорх венийн судсанд гуурс тавих
- Төвийн венээс цус авах
- Хошуувчаар хүчилтөрөгч өгөх
- Кардиомонитортой ажиллах
- Өвчтэй хүүхдийн эх, эцэгтэй харьцах, зөвлөгөө өгөх
- Бусад мэргэжлийн эмч, сувилагч нартай хамтран ажиллах
- Сурганы ур чадвар: эмч, сувилагчдад сургалт явуулахад оролцох
- Амьдралын төгсгөлийн шатанд байгаа хүүхдийн эцэг, эхтэй харьцах

## Хандлага

- Эх, эцэгт хүүхдийн цусны өвчний тухай ойлгуулах
- Халдварт хамгааллын дэглэм баримтлах
- Хүүхдийн тусламжийг сайжруулахтай холбоотой гарч буй өөрчлөлтийг дэмжих

## Цус, хавдрын эмгэгүүд (тойролт 2-8)

### Мэдлэг

- Цус, цус бүтээх эрхтний анатом, физиологийн онцлог
- Гемофили, шалтгаан, эмгэгжам, эмнэл зүй, оношлогоо, эмчилгээ
- Тромбоцитопени шалтгаан, эмнэлзүй, оношлогоо, эмчилгээ
- Цус төлжилтгүйдлийн цус багадалт шалтгаан, эмгэгжам, эмнэлзүй, оношлогоо, эмчилгээ, сэргийлэлт
- Цочмог лейкоз шалтгаан, эмгэгжам, эмнэлзүй, оношлогоо, эмчилгээ
- Цусны бүлэг, цус, цусан бүтээгдэхүүн хийх заалт, хадгалах
- Цус, цус бүтээх эрхтний эмгэгтэй өвчтний диспансерийн хяналт
- Төмөр ба аминдэм дутагдлын цус багадалт шалтгаан, эмгэгжам, эмнэлзүй, оношлогоо, эмчилгээ, сэргийлэлт
- Архаг лейкоз шалтгаан, эмгэгжам, эмнэлзүй, оношлогоо, эмчилгээ
- Лимфогрануломатоз шалтгаан, ангилал, эмгэгжам, эмнэлзүй
- Хүүхдэд тохиолдох хавдрууд
- Гистиоцитоз
- Цусны өвчний клиник фармакологи, диспансерийн хяналт

### Ур чадвар

- Цусны эмгэгтэй хүүхдэд эмнэлзүйн үзлэг хийх
- Цусны бүлэг тодорхойлох
- Цус, цусан бүтээгдхүүн сэлбэх
- Нугасаар тариа хийх
- Лейкозын протокол эмчилгээ
- Хамрын цус алдалтад тусlamж үзүүлэх
- Лейкоztой хүүхдийн амны шархлааг эмчлэх
- Цусны дэлгэрэнгүй, биохими, иммунологи, нян судлал, серологи зэрэг хүүхдэд элбэг хийгддэг шинжилгээг бичих, тэдгээрт гарсан өөрчлөлтийг илрүүлэх
- Ясны хэмийн шинжилгээ авах, дүгнэх
- Өвчтэй хүүхдийн эх, эцэгтэй харьцах, зөвлөгөө өгөх
- Бусад мэргэжлийн эмч, сувилагч нартай хамтран ажиллах
- Сурганы ур чадвар: эмч, сувилагчдад сургалт явуулахад оролцох

- Амьдралын төгсгөлийн шатанд байгаа хүүхдийн эцэг, эхтэй харьцах

**Хандлага**

- Эх, эцэгт хүүхдийн цусны өвчний тухай ойлгуулах
- Халдварт хамгааллын дэглэм баримтлах
- Хүүхдийн тусламжийг сайжруулахтай холбоотой гарч буй өөрчлөлтийг дэмжих

### **Дүрс оношлогоо шинжилгээний аргууд (тойролт 2-13)**

**Мэдлэг**

- Дүрс оношилгоо, шинжилгээний аргууд
- Хүүхдийг дүрс оношилгоо, шинжилгээнд бэлтгэх

**Ур чадвар**

- Рентген шинжилгээнд дүгнэлт хийх
- Эхо шинжилгээнд дүгнэлт хийх
- Компьютер шинжилгээний заалт гаргах, дүгнэлт хийх
- Соронзон резонанс томографийн шинжилгээнд заалт гаргах, дүгнэлт хийх

### **Хүүхдийн халдварт өвчин (тойролт 2-14)**

**Мэдлэг**

- Агаар дуслын замын халдварт өвчинүүд, тархалт, шалтгаан, ангилал, эмгэгжам, эмнэлзүй, оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт
- Ходоод гэдэсний замын цочмог халдварт өвчинүүд, тархалт, шалтгаан, ангилал, эмгэгжам, эмнэлзүй, оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт
- Халдварт шар эмгэгжам, ангилал, эмнэлзүй, эмчилгээ, оношлогоо, сэргийлэлт
- Тууралтат өвчинүүдийн ялган оношлогоо
- Бусад халдварт өвчинүүд /антропоноз, зооноз, бруцеллёз, тарваган тахал/
- ДОХ-ын халдвартай хүүхдийн тусламж
- Халдварт өвчиний үеийн клиник фармакологи, диспансерийн хяналт

**Ур чадвар**

- Тууралтат өвчинүүдийг ялган оношлох
- ДОХ-ын халдвартай хүүхдийн тусламж
- Цусны дэлгэрэнгүй, биохими, иммунологи, нян судлал, серологи зэрэг хүүхдэд элбэг хийгддэг шинжилгээг бичих, тэдгээрт гарсан өөрчлөлтийг илрүүлэх
- Өвчтэй хүүхдийн эх, эцэгтэй харьцах, зөвлөгөө өгөх

## Хандлага

- Эх, эцэгт хүүхдийн асаргаа сувилгааны талаар зөвлөх
- Хүүхдийн тусламжийг сайжруулахтай холбоотой гарч буй өөрчлөлтийг дэмжих

## Дархлаа ревматологи (тойролт 2-15)

### Мэдлэг

- Хэрлэг өвчний шалтгаан, ангиалал, эмгэгжам, эмнэлзүй, оношлогоо, эмчилгээ, сэргийлэлт
- Хэрлэгийн гаралтай хавхлагийн гажгийн оношлогоо, гемодинамикийн онцлогууд
- Хэрлэгийн бус шалтгаант зүрхний үрэвсэл
- Холбогч эдийн эмгэгүүд ялган оношлогоо, эмчилгээ, менежмент
- Хүүхдийн дархлаа тогтолцоо, өөрчлөлтийн шалтгаан, дархлааны эмгэг, эмнэлзүйн илрэл, оношлогоо, эмчилгээ, сэргийлэлт
- Геморрагический васкулит оношлогоо, эмчилгээ
- Хэрэх төст үений үрэвсэл
- Чонон яр
- Ревматологийн эмгэгийн эмчилгээний клиник фармакологи, диспансерийн хяналт

### Ур чадвар

- Ревматологийн эмгэгтэй хүүхдэд эмнэлзүйн үзлэг хийх
- Үений эхо харах, дүгнэлт өгөх
- Ревматологийн эмгэгийг эмчлэх
- Цусны дэлгэрэнгүй, биохими, иммунологи, нян судлал, серологи зэрэг хүүхдэд элбэг хийгддэг шинжилгээг бичих, тэдгээрт гарсан өөрчлөлтийг илрүүлэх
- Өвчтэй хүүхдийн эх, эцэгтэй харьцах, зөвлөгөө өгөх
- Бусад мэргэжлийн эмч, сувилагч наrtай хамтран ажиллах
- Сурганы ур чадвар: эмч, сувилагчдад сургалт явуулахад оролцох

## Хандлага

- Эх, эцэгт хүүхдийн зүрхний гажгийн тухай ойлгуулах
- Эхийг урамшуулан магтах, мэдлэгийг шалгах
- Эхэд зөвлөгөө өгөх 4 зарчмыг ямагт баримтлах
- Хүүхдийн тусламжийг сайжруулахтай холбоотой гарч буй өөрчлөлтийг дэмжих

## **Удамшлын өвчнүүд (тойролт 2-16)**

Мэдлэг

- Хромосомын өвчнүүд /Дауны өвчин, Тернерийн хамшинж, Кланфейльтерийн хамшинж зэрэг/
- Удамшлын эсэргийн эмгэгүүд /Аминоацидури, органикацидури зэрэг
- Муковисцидоз
- Төрөлхийн гажигтай хүүхдийн эрт үеийн оношлогоо
- Бусад эмгэгүүд

Үр чадвар

- Өвчтэй хүүхдийн эх, эцэгтэй харьцах, зөвлөгөө өгөх
- Бусад мэргэжлийн эмч, сувилагч наrtай хамтран ажиллах

Хандлага

- Эх, эцэгт хүүхдийн асаргаа, сувилгааны талаар зөвлөх

## **Өсвөр үе (тойролт 2-17)**

Мэдлэг

- Өсвөр насныхан, тэдэнд тулгамдаж буй эрүүл мэндийн асуудлууд, тусlamж үйлчилгээ
- Өсвөр насны охидод тохиолдох НҮЭМ-ийн асуудлууд. Охидод үзлэг хийх
- Өсвөр насны хөвгүүдэд тохиолдох урологийн асуудлууд. Хөвгүүдэд үзлэг хийх
- Өсвөр насныханд тулгамдаж буй сэтгэцийн эрүүл мэндийн асуудлууд, тусlamж үйлчилгээ
- Жирэмслэхээс сэргийлэх аргууд. Зөвлөгөө өгөх

Үр чадвар

- Өсвөр насныхны сэтгэл зүйн онцлог. Өсвөр насныхан, тэдний эцэг эх, асран хамгаалагчид зөвлөгөө өгөх
- Бусад мэргэжлийн эмч, сувилагч наrtай хамтран ажиллах

Хандлага

- Эх, эцэгт өсвөр насны хүүхэдтэй харилцах талаар зөвлөх

## **Нүдний зонхилон тохиолдох өвчнүүд (тойролт 2-18)**

Мэдлэг

- Хүүхдийн нүдний салстын өвчнүүд

- Холын ба ойрын харалган, хараа хамгаалал
- Нүдний гэмтэл, анхны яаралтай тусlamж

Ур чадвар

- Хүүхдийн хараа шалгах, хамгаалах
- Гэмтлийн анхан шатны тусlamж үзүүлэх
- Өвчтэй хүүхдийн эх, эцэгтэй харьцах, зөвлөгөө өгөх
- Бусад мэргэжлийн эмч, сувилагч наrtай хамтран ажиллах

Хандлага

- Эх, эцэгт хүүхдийн асаргаа, сувилгааны талаар зөвлөх
- Хүүхдийн харалган, осол гэмтлээс сэргийлэх

### **Хүүхдийн сэтгэцийн эмгэгүүд (тойролт 2-19)**

Мэдлэг

- Хүүхдийн сэтгэцийн хөгжлийн үе шатууд
- Сэтгэцийн тулгамдсан асуудлууд
- Хэт хөдөлгөөнтөл, анхаарал сульдах эмгэг
- Архи, тамхи, мансуурах бодисын хэрэглээ, үзүүлэх тусlamж, сэргийлэлт
- Хүүхдийн хүчирхийлэл

Ур чадвар

- Хүүхдийн сэтгэцийн хөгжлийг үнэлэх
- Сэтгэцийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх
- Архи, тамхи, мансуурах бодисын хэрэглээнээс сэргийлэх
- Хүүхдийн хүчирхийллийг илрүүлэх, тусlamж үзүүлэх
- Өвчтэй хүүхдийн эх, эцэгтэй харьцах, зөвлөгөө өгөх
- Бусад мэргэжлийн эмч, сувилагч наrtай хамтран ажиллах

Хандлага

- Сэтгэцийн эмгэгээс хүүхдийг хамгаалах

### **Эмгэг судлал тойролт (2-20)**

Мэдлэг

- Онош бичилт, түүний стандарт
- Эмгэг судлалын шинжилгээний зорилго, зорилт

- Амьд сорьцын шинжилгээний заалт, заавар, журам, үндсэн шаардлага

#### Үр чадвар

- Хүүхдэд зонхилон тохиолдох эмгэгүүдийн эмгэг судлалын шинжилгээний өөрчлөлтийг үнэлэх
- Эмгэг анатомийн суурь мэдлэгийг бататгах
- Бусад мэргэжлийн эмч, сувилагч нартай хамтран ажиллах

#### Хандлага

- Эмч, эмнэлгийн мэргэжилтний хоорондын харилцаа, хандлага, ёс зүйн хэм хэмжээг мөрдөх зөв хандлага

### Загвар 1

#### Ажлын байрны сургалт (On-the-Job Training)

Аргачлал	Суралцаг ч эмчийн тоо	Үргэлжлэх цаг, давтамж	Сургалт явагдах газар	Үйлчлүүлэгч / Хэрэглэгдэх ҮҮН	Удирдагч, хамтрагч
Амбулаторийн үзлэг хийх	1	3 цаг 7 хоногт 2 удаа	Амбулатори	Үйлчлүүлэгч	Эмнэлзүйн сурга багш
Хяналтын тойрон үзлэг хийх	3-5	1 цаг өдөр бүр	Тасаг	Үйлчлүүлэгч	Эмнэлзүйн сурга багш
Сургалтын тойро үзлэг хийх	20 хүртэлх	1 цаг 7 хоногт 1 удаа	Сургалтын өрөө танхим	Слайд	Эмнэлзүйн сурга багш
Мэс засалд оролцох	1	Тохиолдол байгаа үед	Мэс заслын өрөө	Үйлчлүүлэгч	Эмнэлзүйн сурга багш
ХӨЦМ	1	Хүүхэд болон асран хамгаалаг	Амбулатори	Хүүхэд, эцэг, эх, асран хамгаалагч	Эмнэлзүйн сурга багш
Гардан үйлдэл хийх	1-2	Тохиолдол байгаа үед	Яаралтай тусlamжийн өрөө	Үйлчлүүлэгч	Эмнэлзүйн сурга багш

#### Хяналтын тойрон үзлэг:

Хэвтэн эмчлүүлж байгаа үйлчлүүлэгчийн биеийн байдлыг суралцагч эмч нь эмнэлзүйн сургагч багшид (бусад эмч) танилцуулах зорилготой үзлэг бөгөөд суралцагч эмч нь урьдчилан бие даан өвчний түүх, сувилагчийн тэмдэглэлийг үзэж танилцан, үйлчлүүлэгчтэй уулзаж, асуумж цуглуулж (ганцаарчилсан үзлэг), эмнэл зүйн сургагч багшид /бусад эмч/ танилцуулахад бэлдэнэ. Танилцуулга хийхдээ хувь хүний мэдээллийг анхаарна. Танилцуулгыг сургалтын өрөө, танхим эсвэл үйлчлүүлэгчийн өрөөнөөс гадна хийх ба үйлчлүүлэгчийн орны дэргэдэх тойрон үзлэгийг эмнэлзүйн сургагч багштай (бусад эмч) хамт хийнэ. Хяналтын тойрон үзлэгээр үйлчлүүлэгчээс асуумж авах үзлэг хийх аргад суралцана.

## Сургалтын тойрон үзлэг:

Сургалтад тохиромжтой 1-2 үйлчлүүлэгчийг сонгож, үйлчлүүлэгчийн биеийн байдлыг суралцагч эмч нь танилцуулах ба бусад оролцогчид /хамтран суралцагч эмч, эмнэлзүйн сургагч багш, бусад багш/ асуулт тавьж, хэлэлцүүлэг өрнүүлнэ.

Нэг тохиолдолд 30-60 минут зарцуулна. Үүний дараа үйлчлүүлэгчийн орны дэргэд үзлэг хийнэ. Хэлэлцүүлгийн явцад эмнэлзүйн таамаглал дэвшүүлэх, онош тавих зэрэгт суралцана.

## Загвар 2

### Танхимын сургалт

Аргачлал	Суралцагч эмчийн тоо	Үргэлжлэх цаг, давтамж	Сургалт явагдах газар	Үйлчлүүлэгч/Хэрэглэгдэхүүн	Удирдагч, хамтрагч
Бие даалт	1	Тохиромжтой, чөлөөт цаг	Гэртээ, номын сан	Ном, интернет орчин	Эмнэлзүйн сургагч багш
Лекц	10 хүртэл	7 хоногт 2 удаа 1 цаг	Сургалтын анги, танхим	Слайд	Эмнэлзүйн сургагч багш
Журнал клуб	10 хүртэл	7 хоногт 1 удаа 1 цаг	Сургалтын анги, танхим	Слайд, эрдэм шинжилгээний өгүүлэл	Эмнэлзүйн сургагч багш
Симуляци /дуураймал орчин/	5 хүртэл	7 хоногт 1 удаа 1 цаг	Яаралтай тусламжийн өрөө	Хамтран суралцагч эмч, манекин	Эмнэлзүйн сургагч багш

## Загвар 3

### Үйл ажиллагааны хуваарь

#### Амьсгалын эрхтэн тогтолцооны эмгэг

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан
-08:20	Ганцаарчилсан үзлэг	Ганцаарчилсан үзлэг	Ганцаарчилсан үзлэг	Ганцаарчилсан үзлэг	Ганцаарчилсан Үзлэг
08:20-09:30	Хяналтын тойрон үзлэг	Хяналтын тойрон үзлэг	Хяналтын тойрон үзлэг	Хяналтын тойрон үзлэг	Хяналтын тойрон үзлэг
09:30-	Эмнэлзүйн тохиолдол хэлэлцэх		Эмнэлзүйн тохиолдол хэлэлцэх		Эмнэлзүйн тохиолдол хэлэлцэх
12:00-13:00		Лекц, семинар			
14:00-16:20	Симуляци /дуураймал орчин/	Чиглүүлэгч эмчтэй ажиллах уулзалтын цаг	Сургалтын тойрон үзлэг	Лекц, семинар	Журнал клуб

## ДОЛОО. ҮНЭЛГЭЭ, ЭРГЭН ЗӨВЛӨГӨӨ

### 7.1 Суралцагч эмч ба хариуцагч

Сургалтын 2 жилийн хугацаанд суралцагч эмч бүрт хэрхэн ахин дэвшиж байгаа,

хэрхэн сайжруулах тухай эргэн зөвлөгөө өгөх, суралцагч эмчийн хувийн төлөвлөгөөний (*career plan*) талаар зөвлөлдөх, тэднийг хариуцан ажиллах хүн ((*mentor*) цаашид “хариуцагч” гэх)-ийг оноож хуваарилна. Суралцагч эмч нь сургалт эхлэх үед хариуцагчтай уулзах ба цаашид 2-3 сар тутамд 1 удаа уулзаж ярилцан, үнэлгээтэй танилцаж, эргэн зөвлөгөө авна.

## 7.2 Суралцагч эмч ба эмнэл зүйн сургагч багш

Суралцагч эмчийн тойролт бүрт сургалт удирдах эмнэл зүйн сургагч багшийг оноож хуваарилна:

- Суралцагч эмч нь тухайн тойролт эхлэхээс өмнө эмнэл зүйн сургагч багштай уулзаж, тойролтын хугацаанд тавьсан зорилтоо ярилцана.
- Суралцагч эмч нь тойролтын явцад тавьсан зорилтод хүрэхийн тулд дутагдаж байгаа зүйл, түүнийг нөхөхөд хэрэгцээтэй байгаа зүйлийн тухай эмнэл зүйн сургагч багштай ярилцана.
- Суралцагч эмч нь тойролт дуусахад эмнэл зүйн сургагч багштай ярилцлага хийж, сургалттай холбоотой асуудлаар заавар, зөвлөгөө авна.

## 7.3 Үнэлгээний арга

### 7.3.1 Төгсөлтийн шалгалт

“Хүүхэд судлал”-ын сургалтын төгсөлтийн шалгалтад тэнцсэн тохиолдолд “Хүүхдийн эмч”-ийн үнэмлэх олгоно.

### 7.3.2 Явцын үнэлгээ

Явцын үнэлгээг тойролт хийх явцад, тойролт бүрийн дараа хийнэ. Явцын үнэлгээний хувь 80%-иас доошгүй байна. Үнэлгээнд дараах аргуудыг ашиглана.

### 7.3.3 Ажлын байранд-суурилсан үнэлгээ (*Workplace-based Assessment*)

#### 360 хэмийн үнэлгээ (360-Degree Assessment):

Суралцагч эмчийн мэргэжлийн байх (*professionalism*) болон зохион байгуулагч, манлайлагч (*leader*) байх зэргийг үнэлэхэд хэрэглэнэ. 1 жилийн сургалтын дунд үе болон төгсөх үед хийнэ. Тойролтыг удирдсан эмнэл зүйн сургагч багш, сувилахуйн мэргэжилтэн, тухайн тасаг, нэгжийн хамтран ажилласан эмч, эмнэлгийн мэргэжилтэн, өвчтөн зэрэг нийт 5 хүн тус тусдаа үнэлнэ. Үнэлгээ хийх хүнийг сургалтын албанаас сонгоно. Үнэлгээний дүнг суралцагч эмч болон хариуцагчид танилцуулж, үнэлгээнд үндэслэсэн эргэн зөвлөгөөг хариуцагчаас суралцагчид өгнө.

#### Mini-CEX/Эмнэл зүйн дасгал үнэлгээ (Min-Clinical Evaluation Exercise) :

Зайлшгүй таньж мэдэх 22 шинж тэмдгээс тойролт бүрт 5-аас доошгүй шинж тэмдгийг тус бүр 3-аас доошгүй удаа, нийт 15-аас доошгүй удаа үнэлгээ хийнэ. Өөр тойролтонд ижил шинж тэмдгээр үнэлгээ хийсэн ч болно. (Жишээ нь: Дотрын тойролтод халуурах шинж тэмдгийг оролцуулан 5 шинж тэмдгээр үнэлгээ хийсэн бол хүүхдийн тойролтод ч халуурах шинж тэмдгийг оролцуулан 5 шинж тэмдгээр

үнэлгээ хийж болно). Үнэлгээ хийх эмчийг эмнэл зүйн сургагч багш эсвэл тухайн тасаг, нэгжийн туршлагатай эмч нараас суралцагч эмч өөрөө сонгох ба тухайн сонгосон эмч шууд ажиглаж, үнэлгээ хийсний дараа үр дүнг суралцагч эмчид танилцуулж, цаашид хэрхэн сайжруулах зөвлөгөө заавал өгнө.

#### **Гардан үйлдлийн ур чадварын шууд ажиглалт/DOPS (Direct Observation of Procedural Skills):**

Зайлшгүй суралцагч эмч нараас суралцсан лекц, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний сургалтын үеэр эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа хийсэн материал зэрэг сургалттай холбоотой бусад бичиг баримтыг үр дүн болгож хадгална.

#### **Портфолио үнэлгээ (Portfolio Assessment):**

Суралцагч эмч нь сургалтын хугацаанд суралцсан лекц, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний сургалтын үеэр эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа хийсэн материал зэрэг сургалттай холбоотой бусад бичиг баримтыг үр дүн болгож хадгална.

#### **7.4 Үнэлгээний дүнг хянах**

- 36-хэмийн үнэлгээний дүнг сургалтын алба хяналт тавьж, хадгална. Үнэлгээний дүнг суралцагч эмч, хариуцагчид танилцуулах ба бусадтай хуваалцахгүй байхыг анхааруулна.
- Mini-CEX болон DOPS үнэлгээний дүнг суралцагч эмч өөрөө хадгална.
- Портфолиод үнэлгээ, эмнэл зүйн сургагч багштай зөвлөлдсөн асуудал, өгсөн зөвлөгөөг бичиж тэмдэглэн хадгална.
- Суралцагч эмч нь тойролт бүрийн төгсгөлд Mini-CEX болон DOPS үнэлгээний дүнг сургалтын албандаа хүлээлгэн өгнө.
- Сургалтын алба үнэлгээний дүнг сургалтын хяналтын зөвлөлд танилцуулах ба сургалтын төгсгөлд хариуцагчаас суралцагч эмчид зөвлөгөө өгнө.

#### **7.5 Сургалтын төгсөлтийг шийдвэрлэх**

- Тойролт бүрт хийгдсэн Mini-CEX болон DOPS үнэлгээний дүнг нэгтгэсний үндсэн дээр суралцагч эмчийг тухайн тойролтыг төгсгөх эсэх шийдвэрийг сургалтын хяналтын зөвлөл гаргана. Сургалтын хяналтын зөвлөл нь тойролт бүрт хийгдсэн Mini-CEX болон DOPS үнэлгээний дүн, 360 хэмийн үнэлгээний нэгдсэн дүн, суралцагчийн сургалтын ирц, зайлшгүй танъж мэдэж суралцах шинж тэмдэг, өвчиний тохиолдол, гардан үйлдлийн тоог харгалзан сургалтын төгсөлтийн эцсийн шийдвэрийг гаргана.

Шийдвэр гаргах шалгуур нь:

- Зайлшгүй сургалтад оролцсон байх өдрийн тоо буюу сургалтын ирц: Хөдөлмөрийн тухай хуульд заасан цалинтай амралтын өдрийн тоо, хүндэтгэх шалтгаантай авах амралтын өдрийн тоог оруулаад сургалтын хугацаанд авах

амралтын өдрийн тоог сургалтын тойролт тус бүрийн нийт өдрийн 20%-аас хэтрүүлэхгүй байна. Сургалтын ирц хангалтгүй бол тухайн тасарсан сургалтын өдөр, агуулгыг нөхүүлнэ.

- Зайлшгүй таньж мэдэх шаардлагатай 26 шинж тэмдгээс 1 жилийн турш 18-аас доошгүйг оношилж, эмчлэн туршлага хуримтлуулсан байна. Зайлшгүй туршлага хуримтлуулсан байх шаардлагатай өвчний тохиолдлын тоо нь:
  - Хүүхдийн дотрын эмгэгийн тойролт бүрт заагдсан өвчний бүх тохиолдлыг тус бүр 30-аас доошгүй удаа үзэж, туршлага хуримтлуулсан байна.
  - Хүүхдийн мэс заслын тойролтоор 5-аас доошгүй удаа мэс засалд оролцон мэс заслын дараах үзлэгийг тус бүр 5-аас доошгүй хийж, туршлага хуримтлуулсан байна.
  - Хүүхдийн яаралтай тусламжийн тойролтоор 100 хүртэлх хүүхдэд анхан шатны тусламж үзүүлсэн байна.
  - Хүүхдийн амь тэнссэн үеийн тусламж, үйлчилгээг 10 хүртэлх хүүхдэд үзүүлсэн байна.
  - Зайлшгүй суралцах 56 гардан үйлдлээс 44-ээс доошгүйг хийж гүйцэтгэн, туршлага хуримтлуулсан байна.
- Тойролт бүрийн төгсгөлд эсвэл 1 жилийн сургалтын эцэст суралцагчийг төгсгөх боломжгүй гэсэн шийдвэр гарсан тохиолдолд шалтгаан, цаашид сургалтыг хэрхэн төгсгөх талаарх шийдвэр, зөвлөмжийг сургалтын алба болон хариуцагчаас тухайн суралцагч эмчид тайлбарлаж өгнө.

## НАЙМ. ХЭРЭГЖҮҮЛЭЛТ (хөтөлбөрийг нэвтрүүлэх ба хэрэгжүүлэх)

### 8.1 Сургалтын хяналтын зөвлөл

- Эрүүл мэндийн яамны дэргэдэх Хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүд, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Монгол-Японы эмнэлэг, Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төвийн хүүхдийн эмнэлэг хариуцсан дэд захирал (тэнхимийн эрхлэгч), сургалтын албаны дарга, мэргэжилтэн, хүүхдийн төрөлжсөн мэргэжлийн тасгийн эрхлэгч, тухайн тойролтын сургалт хариуцагч, сувилахуйн албаны төлөөлөл, эмнэлгийн захиргааны төлөөлөл, суралцагч эмчийн төлөөллөөс бүрдэнэ. Сургалтын хяналтын зөвлөл нь эмнэлгийн тусламж, үйлчилгээний байгууллагын даргын шууд удирдлага дор ажиллана.
- Сургалтын хяналтын зөвлөл нь сар бүр хуралдана.
- Сургалтын хяналтын зөвлөл нь суралцагч эмчийн сургалт, тулгарсан асуудалтай танилцах, суралцагч эмчтэй холбоотой бүх асуудлыг ярилцаж, шийдвэрлэх арга замыг судалдаг бүтэц байна.
- Сургалтын хяналтын зөвлөлийн гишүүд нь сургалтыг илүү сайжруулахын тулд өөрийн мэдлэг, боловсролоо дээшлүүлэхийг зорьж ажиллана.

### 8.2 Хөтөлбөрийн хяналт

- Сургалтын алба хөтөлбөрт хяналт хийнэ.

- Хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалтын төлөвлөгөө гаргах, эмнэл зүйн сургагч багшид чиглэсэн сургалт (*Faculty Development*), суралцагч эмчийн нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх, шаардагдах санхүүжилтийг төсөвт тусгах зэргийг сургалтын алба хариуцна.
- Хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт хийх шаардлагатай тохиолдолд сургалтын хяналтын зөвлөлд оруулж хэлэлцүүлэн, өөрчлөлт хийнэ. Энэ тухай Эрүүл мэндийн хөгжлийн төвд албан бичгээр ажлын 10 хоногт багтаан мэдэгдэнэ.

### 8.3 Сургалтын танилцуулга (*Orientation*)

Сургалт эхлэхийн өмнө тойролт бүрийн сургалтын төлөвлөгөө (*Program*) болон хөтөлбөрийн (*Curriculum*) агуулгын уялдааг тодорхой ойлгох, сургалт эрхлэх байгууллага (эмнэлэг, эрүүл мэндийн төв), түүний үйл ажиллагаа, эмчилгээ, оношилгооны аюулгүй байдал, халдварт хамгааллын тухай суралцагч эмчид гүнзгий ойлголт өгөх зорилго бүхий танилцуулга хичээлийг зохион байгуулна.

## Хавсралт 1

### 360 ХЭМИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Суралцагч эмчийн нэр \_\_\_\_\_

Үнэлгээ хийгч:  Эмнэлзүйн сургагч багш  Эх баригч  Сувилагч  Бусад \_\_\_\_\_

Суралцагч эмчийг ажигласны үндсэн дээр, бусдаас сонссон, мэдсэн зүйл дээр бус, суралцагч эмчийн зан үйлийг хэр давтамжтай байсныг өөрийнхөө ажигласнаар оноо тавина уу.

<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Үнэлэх боломжгүй	Ховор /≤19%/	Заримдаа /20-49%/	Ихэнхдээ /50-79, /	Бараг бүгд /≥80%/

Үйлчлүүлэгч/гэр бүлийн хувийн асуудлыг хүндэтгэдэг/ Амаржих газрын бичиг баримтын бүрэн гүйцэт, гаргацтай, цаг хугацаанд нь хөтөлдөг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Үйлчлүүлэгчдийн эрүүл мэндийн асуудалд өөрийн санаачлагаар хувь нэмрээ оруулдаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Үйлчлүүлэгчийн бие даасан байдлыг хүндэтгэж, үйлчлүүлэгчид тохирсон хамгийн зөв шийдвэрийг гаргахыг хичээн зүтгэл гаргадаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Хувь хүний онцлогийг харгалзан үйлчлүүлэгчийг хүндэтгэн эмчилгээ зөвлөгөө өгдөг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Өөрийн эмнэлзүйн ур чадварын дээшлүүлэхийн тулд сургалт болон бусад боломжийг алдалгүй ашигладаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Өөрийн анагаах ухааны онолын мэдлэгээ дээшлүүлэхийн тулд бие даан суралцдаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Бусад эмнэлгийн мэргэжилтэнтэй хамтран ажилладан.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4

Эмнэлэг доторх бусад эмнэлгийн мэргэжилтэнүүдтэй хамтран ажилладаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Эрүүл мэндийн тусlamж үйлчилгээнд зохион байгуулах, манлайлах үүрэгтэйг ухамсарладаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Эмнэлэг доторх тусlamж үйлчилгээнд зохион байгуулах, манлайлах үүрэгтэйг ухамсарладаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4

1 эсвэл 4 оноо тавьсан бол тухайн асуултын дагуу саналаа бичнэ үү.

## Хавсралт 2

### ЭМНЭЛЗҮЙН УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (MINI-CEX)

Энэхүү үнэлгээ нь эмнэлзүйн үзлэг хийх үед суралцагчийн ур чадвар, бодит үзлэг хийх ур чадвар, эмнэлзүйн сэтгэлгээ, асуудал шийдвэрлэх чадвар, зөвлөгөө өгөх, зохион байгуулах зэрэг цогц чадамжийг нэгэн зэрэг үнэлдэг 9 онооны системээр үнэлдэг арга юм. Үүнд:

- 1-3 оноо нь хангалтгүй
- 4-6 оноо нь хангалттай
- 7-9 оноо нь хангалттай маш сайн

### ҮНЭЛГЭЭНИЙ ЗАГВАР ХУУДАС(MINI-CEX)

Шалгалт авсан:.....он.....сар.....өдөр

Шалгагчийн нэр:.....

Шалгуулагчийн нэр:..... овог..... нэр

Шалгалт авсан орчин (доогуур нь зур): тасагт, амбулаторид, стандарт өвчтөн,

Үйлчлүүлэгчийн нас ..... Хүйс: эр\эм (доогуур нь зур)

Үзлэг (доогуур нь зур): анх удаа, давтан

Үйлчлүүлэгчийн биеийн байдал (доогуур нь зур): хүнд, дунд зэрэг, хөнгөн

Шалгалтын зорилго:.....

1. Асуумж авах ур чадвар (ажиглагдаагүй бол 0 оноо)

1	2	3	4	5	6	7	8	9
хангалтгүй			хангалттай				маш сайн	

2. Бодит үзлэг хийх чадвар (ажиглагдаагүй бол 0 оноо)

1	2	3	4	5	6	7	8	9
хангалтгүй			хангалттай				маш сайн	

3. Эмнэлзүйн оношилгоо, асуудал шийдвэрлэх чадвар (ажиглагдаагүй бол 0 оноо)

1 2 3

Хангалтгүй

4 5 6

хангалттай

7 8 9

маш сайн

4. Зөвлөгөө өгөх ур чадвар (ажиглагдаагүй бол 0 оноо)

1 2 3

Хангалтгүй

4 5 6

хангалттай

7 8 9

маш сайн

5. Үр дүнтэй зохион байгуулах ур чадвар (ажиглагдаагүй бол 0 оноо)

1 2 3

Хангалтгүй

4 5 6

хангалттай

7 8 9

маш сайн

6. Үйлчлүүлэгчид тавьж буй анхаарал, хүнлэг байдал (ажиглагдаагүй бол 0 оноо)

1 2 3

Хангалтгүй

4 5 6

хангалттай

7 8 9

маш сайн

7. Ерөнхий эмнэлзүйн ур чадвар (ажиглагдаагүй бол 0 оноо)

1 2 3

Хангалтгүй

4 5 6

хангалттай

7 8 9

маш сайн

Шалгагч багшийн зүгээс Mini-CEX үнэлгээнд өгөх сэтгэл ханамж:

(1-9 оноог өгнө) .....

Шалгуулагчийн зүгээс Mini-CEX үнэлгээнд өгөх сэтгэл ханамж:

(1-9 оноог өгнө) .....

**ГАРДАН ҮЙЛДЛИЙН УР ЧАДВАРЫН ШУУД АЖИГЛАЛТ**  
**/DOPS/ -ЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Он, сар, өдөр\_\_\_\_\_

Суралцагч эмчийн нэр: \_\_\_\_\_ Үнэлгээ хийгч эмчийн нэр: \_\_\_\_\_

Сургалт эрхлэх байгууллага\_\_\_\_\_

Тасаг\_\_\_\_\_

Гардан үйлдэл:

Одоо хүртэл суралцагч эмчийн тухайн гардан үйлдлийг хийсэн  
тоо\_\_\_\_\_

Үнэлгээ	Хангалтгүй	Завсрын	Хангалттай	Ажиглагдаагүй/ үнэлэх боломжгүй
Хийх гэж буй үйлдлээ үйлчлүүлэгчид тайлбарладаг, үйлчлүүлэгчээс зөвшөөрөл авдаг.				
Гардан үйлдэл хийх бэлтгэлийг зохицой хийдэг.				
Халдвартгүйжүүлэх үйлдлийг гүйцэтгэдэг, багаж хэрэгслийг аюулгүй хэрэглэдэг.				
Арга барилыг чадварлаг гүйцэтгэдэг.				
Өөрийн чадахгүй үйлдлийг ойлгож, шаардлагатай үед тусlamж дууддаг.				
Багаж хэрэгсэл, материалыг цэвэрлэдэг.				
Шаардлагатай бичиг баримтыг гүйцэт бичдэг.				
Гардан үйлдлийг хийх ерөнхий чадвар				

Зөвлөмж:

Сайн тал:

Сайжруулах тал:

Бусад санал:

Сайжруулахын тулд зөвшилцэж, биелүүлэх үйлдэл:

Үнэлгээ хийсэн эмчийн гарын үсэг: \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ / \_\_\_\_\_

Суралцагч эмчийн гарын үсэг: \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ / \_\_\_\_\_

## **СУРГАЛТАД АШИГЛАХ НОМ ЗҮЙ**

1. Хүүхдийн өвчний цогц менежмент, ДЭМБ-ын удирдамж
2. Шабалов Н. П “Детские болезни” Том 1,2 Санкт Петербург 2002
3. Бадалян Л. А “Детские неврология”, Минск, 1984
4. Маркова М. В “Клиническая фармакология педиатрии”, Москва, 1993
5. Малчинхүү “Эрүүл бойжихуй”, УБ, 2001
6. Н. Гэндэнжамц, Д. Малчинхүү “Хүүхдийн уушгины цочмог үрэвсэл”, УБ, 1998
7. Н. Гэндэнжамц, Д. Одонтуяа “Хүүхдийн биеийн харшжуу шүүдэст эмзэгшил”, УБ, 1997 он
8. Н. Гэндэнжамц, Содбилэг “Төмөр дутлын цус багадалт”, УБ, 1998
9. Н. Гэндэнжамц, Г. Агаандорж “Хүүхдийн рапит өвчин”, УБ, 1997
10. Н. Гэндэнжамц, Г. Эрдэнэбилэг “Хүүхдийн анагаах судлалын математик зарим томъёо”, УБ, 1998
11. Ш.Энхтэр. Сэхээн амьдруулахын тэмдэглэлүүд I II боть 2018, 2021 он

### **Нярайн чиглэлээр.**

1. “Нярайн сэхээн амьдруулалт” АНУ-ын орчуулга 2001 он
2. Б.Баясгалантай “Өртөмтгий бүлгийн нярайн хяналт” УБ.. 2004
3. Гэрэлмаа “Нярай судлал” УБ.. 2003 он
4. Гэрэлмаа ба бусад “Нярайг үзэж.шинжлэхүй” УБ.. 2004
5. Гэрэлмаа “Бага жинтэй нярайд үзүүлэх тусламж” УБ., 2004
6. Шабалов И. П. "Неонатология" 1, 2том. Санкт-Петербург, 1998
7. Нярайн нэн шаардлагатай тусламж ба хөхөөр хооллолт, ДЭМБ-ын орчуулга, 2001
8. Нярайн эрүүл мэндийн тулгамдсан асуудлууд, онош эмчилгээний алгоритм гарын авлага. 2011, 2016 он

### **Халдварт өвчний чиглэлээр.**

- 1 Коронавируст халдварт (COVID-19)-ын үед жирэмсэн эмэгтэй, хүүхдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг зохицуулах түр журам, Эрүүл мэндийн сайдын 2020 оны A/222 дугаар тушаал
- 2 Үйлчилгээний зарим байгууллагуудын үйл ажиллагаанд мөрдөх эрүүл ахуй, халдварын сэргийлэлт, хяналтын түр журам, Эрүүл мэндийн сайдын 2020 оны A/249 дүгээр тушаал
- 3 Коронавируст халдварт (COVID-19)-ын тусгаарлан ажиглалтад байгаа хүнд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх түр заавар, тусгаарлан ажиглах байрны мэдээний хуудас, Эрүүл мэндийн сайдын 2020 оны A/278 дугаар тушаал
- 4 “Коронавируст халдварт (COVID-19)-ын батлагдсан болон сэжигтэй цогцсыг оршуулахад баримтлах түр заавар, Эрүүл мэндийн сайдын 2020 оны A/412дугаар тушаал

- 5 Эрүүл мэндийн байгууллагад Коронавируст халдварт (КОВИД-19)-ын тусламж, үйлчилгээнд хэрэглэсэн нэг удаагийн хамгаалах хувцас, хэрэгслийг устгах түр заавар батлах тухай, Эрүүл мэндийн сайдын 2020 оны A/510 дугаар тушаал
- 6 Коронавируст халдвартын оношилгоо, эмчилгээний түр заавар шинэчлэн батлах тухай, Эрүүл мэндийн сайдын 2020 оны өдрийн A/562 дугаар тушаал
- 7 Түр заавар батлах тухай, Эрүүл мэндийн сайдын 2020 оны A/606 дугаар тушаал
- 8 Коронавируст халдварт (COVID-19)-ын оношилгоо, эмчилгээний зааврыг шинэчлэн батлах тухай, Эрүүл мэндийн сайдын 2021 оны A/40 дүгээр тушаал
- 9 Түр журам шинэчлэн батлах тухай, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 101 дүгээр тушаал
- 10 Коронавируст халдварт (COVID-19)-ын оношилгоо, эмчилгээний зааврыг шинэчлэн батлах тухай, Эрүүл мэндийн сайдын 2021 оны A/140 дүгээр тушаал
- 11 Коронавируст халдварт (COVID-19)-ын үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний талаар авах арга хэмжээний тухай, Эрүүл мэндийн сайдын 2021 оны A/ 141 дүгээр тушаал
- 12 Гамшгийн үеийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах заавар батлах тухай, Эрүүл мэндийн сайдын 2021 оны A/182 дугаар тушаал
- 13 Түр журам батлах тухай, Эрүүл мэндийн сайдын 2021 оны A/203 дугаар тушаал
- 14 Түр журам батлах тухай, Эрүүл мэндийн сайдын 2021 оны A/227 дугаар тушаал
- 15 Түр журам, үнэлгээний хуудас батлах тухай, Эрүүл мэндийн сайдын 2021 оны A/239 дүгээр тушаал
- 16 Түр журам батлах тухай, Эрүүл мэндийн сайдын 2021 оны A/285 дугаар тушаал
- 17 Коронавируст халдварт (COVID-19)-ын үед хамгаалах хувцас, хэрэгслийг хэрэглэх заавар 2020 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн ХӨСҮТ-ийн захирлын А34 дүгээр тушаал
- 18 Коронавируст халдварт (COVID-19)-тай хунд хэлбэрийн хатгааны үед амьсгалын замын эмчилгээ, сувилгаа, ажилбар хийхэд халдвартын сэргийлэлт, хяналтын зөвлөмж
- 19 Коронавируст халдвартын цартахлын үед эндоскопийн тасгийн ажиллаж түр заавар
- 20 Коронавируст халдварт (КОВИД-19)-ын үеийн дүрс оношилгооны эмнэлзүйн зөвлөмж
- 21 Коронавируст халдварт (КОВИД-19)-ын үед мэс заслын тусламж, үйлчилгээ үзүүлэх зөвлөмж